**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт**
**Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар**
**2023 оны эхний хагас жил**

2023.07.05.

| Шийдвэрийн дэс дугаар | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Биелэлт | Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удаашир ч байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| МУ-ын хууль | | | | | |
| 1 | 1 | **Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03**<br>39.7. Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана. | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 сарын 02-ны өдрийн “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолын 5-р хавсралт “Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал”-д 3.7 сая төгрөгийг батлуулсан. Аймгийн Засаг даргын 2023 оны “Нэгдсэн эргүүл шалгалт, сурталчилгааны ажил зохион байгуулах тухай” А/94 дүгээр захирамжаар 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдон Сүмбэр сумын 5, 6-р багийн нутгаар 3 нөхөрлөл, 6 өрхийн 17 малчин иргэдэд хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хаврын эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажилласан. Мөн өнжмөл шар өвс, өвөлжөө, хаваржаа, отор нүүдэл, цагаан зээр зэрэгт тандалт хийсэн. тус үйл ажиллагаанд 1,700.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөн Байгаль хамгаалах сан дурын нөхөрлөл бүлгийн гал унтраах багаж хэрэгслийг шалгаж. Тороосон шүүр гөвүүр тоог нэмэгдүүлэх талаарх зөвлөмж өгч ажилласан.<br>**Үр нөлөө:** Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардалд орон нутгийн төсвөөс 3.7 сая төгрөгийг батлуулсан. | 100 | |
| 2 | 2 | **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/** | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах чиглэлээр “Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн 2023 оны | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **2016-12-22**<br>**Дугаар 2017.02.01**<br><br>18.1.1. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | төлөвлөгөө”-г батлуулан төлвлөгөөний дагуу Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн танилцуулга сургалтыг зорилтот өрхийн 35, төрийн болон төрийн бус байгууллагын 378 албан хаагч нийт 413 эцэг, эх асран хамгаалагчдад танилцуулж мэдлэг, мэдээлэл олгосон. Мөн хохирогчийг хамгаалах чиглэлээр 2018 оноос эхлэн хохирогчийг хамгаалах түр хамгаалах байр ажиллуулж 2023 оны эхний хагас жилийн байдлаар 5 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн бөгөөд үүнээс бага насны 2, өсвөр насны 3 хүүхэд үйлчлүүлсэн байна. Хүчирхийллийн хэлбэрээр ангилбал: Бэлгийн хүчирхийллийн хохирогч-2 хүүхэд, үл хайхрах хүчирхийллийн хохирогч 2 хүүхэд, сэтгэл санааны хүчирхийллийн хохирогч 1 хүүхэд үйлчлүүлсэн. Дээрх үйлчлүүлэгчдэд нийт 142 өдрийн түр хамгаалан байрлуулах үйлчилгээг бүрэн үзүүлсэн. Гэр бүлд нь эргэн нэгтгэсэн 4 хүүхэд байна. Мөн үйлчлүүлэгчдийн ар гэрт нь гэр бүлийн харилцаа болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зөвлөгөө мэдээллийг олгосон. Үйлчлүүлэгч нарт анхан шатны суурь хэрэгцээг хангах үйлчилгээ болон мэргэжлийн үйлчилгээг тогтмол үзүүлж ажилласны үр дүнд үйлчлүүлэгчдийн анхан шатны хэрэгцээ хангагдаж, сэтгэл ханамж сайжирсан байна.<br><br>**Үр нөлөө**: аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт 60 хувь | | |
| | 3 | 18.1.2. Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөний 2.4 дэх зорилтод Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хамтдаа хөгжье-хамтдаа хамгаалъя” уриан дор 2023 оны “Хүүхдийн хөгжил, хүүхэд хамгаалал”-ын жил болгон зарласан байна.<br><br>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг Сүмбэр суманд 11.0 сая төгрөг, Шивээговь суманд 3.0 сая төгрөгийг тус тус батлуулан хагас бүтэн жилээр сумдын ИТХ-д тайлагнан ажиллаж байна.<br><br>**Үр нөлөө:** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардалд 2 сум нийт 14.0 сая төгрөгийг батлуулан ажиллаж байна. | 30 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 4 | 18.1.3. Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Аймгийн Засаг даргын 2017 оны А/109 дүгээр захирамжаар “Түр хамгаалах байрыг байгуулан 2018 оноос эхлэн хохирогчдод үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/116 дугаар тушаалаар батлагдсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”-ын дагуу 2023 оны хагас жилийн байдлаар 5 хүүхдэд үйлчилгээ үзүүлэн ажилласан байна. Үүнээс бага насны 2, өсвөр насны 3 хүүхэд үйлчлүүлсэн байна. Түр хамгаалах байрнаас эдгээр үйлчлүүлэгчдэд 142 хоногийн түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлэн ажилласан. Мөн гэр бүлд нь эргэн нэгтгэсэн 4 хүүхэд, үргэлжлүүлэн үйлчилгээ авч байгаа 1 хүүхэд байна. Үйлчлүүлэгч нарт анхан шатны суурь хэрэгцээг хангах үйлчилгээ болон мэргэжлийн үйлчилгээг тогтмол үзүүлж ажилласны үр дүнд үйлчлүүлэгчдийн хэрэгцээ хангагдаж, сэтгэл ханамж сайжирсан байна.<br><br>**Үр нөлөө:** 3 суманд тус бүр нэг нэг түр хамгаалах байр ажиллуулсанаас нэг түр хэмгаалах байраар 5 хүүхэд үйлчлүүлээд байна. | 100 | |
| | 5 | 19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | 2023 оны эхний хагас жилийн байдлаар гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл цагдаагийн байгууллагад 26 бүртгэгдсэн байна. Үүнээс гэмт хэргийн шинжтэй 1 дуудлага, зөрчлийн хэрэг нээж шалгасан 25 дуудлага мэдээлэл цагдаагийн хэлтэст бүртгэгдсэн бөгөөд шийдвэрлэлтийн шатанд байна. Үүний шалтгаан нөхцөлийг тогтооход ахуйн хүрээний архидалт, гэр бүлийн харилцааны үл ойлголцол, эрх мэдлийн зөрүүтэй байдал зонхилж байна.<br><br>Иймд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн сургалтыг зорилтот өрхийн 35, төрийн болон төрийн бус байгууллагын 378 нийт 413 иргэнд танилцуулсан. Мөн тус хуулийн танилцуулга бүхий видео шторкыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан түгээж 510 иргэний хандалт авсан байна. Мөн түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн ар гэрт нь гэр бүлийн харилцаа болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зөвлөгөө мэдээллийг олгосоноор үйлчлүүлэгч нарт анхан шатны суурь хэрэгцээг хангах үйлчилгээ болон мэргэжлийн үйлчилгээг тогтмол үзүүлж ажилласны үр дүнд | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | үйлчлүүлэгчдийн анхан шатны хэрэгцээ хангагдаж, сэтгэл ханамж сайжирсан байна.<br><br>**Үр нөлөө:** Хууль тогтоомжийг сурталчилсан арга хэмжээний тоо-2 хамрагдсан иргэйин тоо-928 | | |
| | 6 | 19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/173, А/251, А/3801 дугаарт тушаалуудаар батлагдсан “Хамтарсан багийн ажиллах, санхүүжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах, хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хүчирхийллийн үндэсний төвтэй хамтран Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн 3 сумын хамтарсан багийн 39 гишүүнд арга зүйн дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Сургалтын үр дүнд хамтарсан багийн гишүүд ажиллах журам, үүрэг, кейс менежмент хийх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллах арга зүй, хууль эрх зүйн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн.<br><br>**Үр нөлөө:** Хамтарсан багийн гишүүдийг мэргэжил арга зүйгээр хангах сургалтын тоо-1,<br><br>сургалтад хамрагдсан гишүүдын тоо-39 | 70 | |
| | 7 | 19.1.3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Аймгийн Засаг даргын 2017 оны А/109 дүгээр захирамжаар “Түр хамгаалах байрыг байгуулан 2018 оноос эхлэн хохирогчдод үйлчилгээ үзүүлж, үйл ажиллагаа тогтмолжсон. Мөн Шивээговь сум, Баянтал сумдад Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулан ажиллуулж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар нэг түр хамгаалах байраар 5 иргэн үйлчлүүлж, нэг цэгийн үйлчилгээний 3 төвөөр 1719 иргэн үйлчлүүлээд байна.<br><br>**Үр нөлөө:** Түр хамгаалах байрны тоо-3<br><br>Нэг цэгийн үйлчилгээний төвийн тоо-3 | 100 | |
| | 8 | 19.1.4. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр | Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | хөтөлбөрт тусгасан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээний хүрээнд 2022 онд 2 зорилт, 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулж 60.0 хувьтай хэрэгжүүлээд байна. Үүнд: Залуучуудын чуулга уулзалт, "Хайрын түүх" гэр бүлийн нэвтрүүлэг, "Яргуй-2023", "Яргуйхан-2023" хүүхдийн урлагийн наадам зэрэг арга хэмжээнд давхардсан тоогоор 944 хүүхэд, залуус оролцсон. Тус арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 15.5 сая төгрөгийг зарцуулсан байна.<br><br>**Үр нөлөө**: 2 бодлогын баримт бичигт 2 зорилт 5 арга хэмжээг тусган батлуулсан.<br><br>Орон нутгийн төсөвт 15.5 сая төгрөгийг тусган батлуулсан. | | |
| | 9 | 19.1.5. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Түр хамгаалах байрны төсөв хөрөнгийг 3 жилийн дунджаар тогтоон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас санхүүжүүлж байна. 2023 онд 8.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Сүмбэр, Шивээговь сумд хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой 14.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт батлуулан зориулалтын дагуу зарцуулж байна.<br><br>**Үр нөлөө:** Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой нийт 22.0 сая төгрөгийг батлуулан зориулалтын дагуу зарцуулж байна. | 100 | |
| | 10 | 19.1.6. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзуулах өрөөг тохижуулахад 6,945,000 төгрөгийн санхүүжилт олгож тогтвортой ажиллах нөхцөлөөр хангасан. Мөн Сүмбэр, Шивээговь сумдын ЗДТГ-ын Нийгмийн боддлогын мэргэжилтэнгүүдийг иж бүрэн тоног төхөөрөмжөөр ханган хохирогчтой уулзах уулзалтын өрөөг шинээр гарган тохижуулсан.<br><br>**Үр нөлөө:** Хохирогчтой уулзах уулзалтын өрөөний тоо-3, 4 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. | 100 | |
| | 11 | 19.1.7. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн | Орон нутагт "Түр хамгаалах байр"-ны үйлчилгээг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн хэлтэс хамтран хариуцаж ажилладаг. Жилд дунджаар 20-22 иргэн үйлчлүүлдэг учир | - | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх хамтран ажиллах хэрэгцээ шаардлага байддаггүй болно. | | |
| | 12 | 19.1.8. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 2023 онд шинээр 2 байгууллага эцэг эхийг зөвлөл байгуулсанаар аймгийн хэмжээнд Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор 57 төрийн болон аж ахуй нэгж байгууллага байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл байгуулан ажиллаж байна. Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор “Эцэг эхийн зөвлөл”-ийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж нийт 40 байгууллагын 65 эцэг эхийн зөвлөлийн дарга, нарийн бичгүүд хамрагдсан байна. Тус үйл ажиллагааны үр дүнд байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн гишүүд хэрхэн ажиллах талаар болон холбоотой хууль тогтоомж, хүүхэд хамгаалал, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн боловсролын чиглэлээр мэдлэг ойлголт нь дээшилсэн. Идэвхи санаачилгатай ажилласан эцэг эхийн зөвлөлийг жилийн эцсээр урамшуулна. | 70 | |
| | 13 | 25.2. Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно. | Аймаг, сумын хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан Цагдаагийн хэлтэст хэсгийн байцаагч 2, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн 1, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэргэжилтэн 1, чиглэлийн ахлах мэргэжилтэн 1, нийт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр 5, сумдад хэсгийн төлөөлөгч 2 ажиллаж байгаа бөгөөд сумдын хамтарсан багийн хуралд 4 удаа оролцож, аймгийн ГБХЗХГ-тай хамтарсан зөвлөгөөнийг улирал бүр зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийн түр хамгаалах байранд 5 иргэнийг авч ажилласанаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 буюу 23,1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | 100 | |
| 3 | 14 | **Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01** | Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж 2021-2024 онд хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/21 дүгээр тушаалын хавсралтаар батлуулан жил бүр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна. 2023 онд 5 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг төлөвлөн батлуулж эхний хагас жилийн | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | байдлаар 80 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу албан хаагчдын ур чадвар, чадавхыг дээшлүүлэх зорилгоор сургалтын нэгдсэн төлөвлөгөөг гарган 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 252 албан хаагчийг хамруулсан. Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд шатны багц сургалтад 1 албан хаагч хамрагдаж байна. Сумын Засаг даргын Тамгын газарт төрийн захиргааны 6 албан тушаалын сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн. Байгууллагын нийт албан хаагчдыг монгол бичгийн сургалтад хамруулж 8 албан хаагч сертификат авсан.<br><br>**Үр нөлөө:** Төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувь | | |
| 4 | 15 | **Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01**<br><br>15.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжлүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг өмнөх баримт бичиг дуусгавар болохоос өмнө батална. /Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./ | Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг 2020 онд боловсруулан Үндэсний хөгжлийн газраар хянуулж, хуульд заагдсан хугацаанд буюу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 04 дүгээр хуралдааны тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>**Үр нөлөө:** Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хуулийн хугацаанд батлуулсан. | 100 | Бүрэн хэрэгжсэн тул хасуулах саналтай байна. |
| | 16 | 18.6. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор батална. | Говьсүмбэр аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Үндэсний хөгжлийн газраар хянуулж хуульд заагдсан хугацаанд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн Шинэ сэргэлтийн бодлоготой уялдуулан аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлуулсан. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | **Үр нөлөө:** Говьсүмбэр аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд батлуулсан. | | |
| | 17 | 21.6. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудын орон нутагт дахь хэрэгжилтийн явц, үр нөлөөний тайланг аймаг, нийслэлийн Засаг даргаас Засгийн газарт тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудын хүрээнд: Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөний 2023 оны эхний хагас жилийн тайланг 75,29 хувийн хэрэгжилттэйгээр 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/729 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Говьсүмбэр аймгийг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны жилийн эцсийн тайланг 92,5 хувийн хэрэгжилттэй, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөний 2022 оны жилийн эцсийн тайланг 88,2 хувийн хэрэгжилттэй, Говьсүмбэр аймгийг 2022 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2022 оны жилийн эцсийн тайланг 90,8 хувийн хэрэгжилтийг 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн А/202 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн 2022 оны жилийн эцсийн тайланг 100 хувийн хэрэгжилттэй, Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичгийг 88.3 хувийн хэрэгжилтийг ханган 2021 оны 11 дүгээр сард хүргүүлсэн. Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт, Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хэлэлцүүлэн, аймгийн Засаг даргын үйл ажиллагааг 84.0 хувиар үнэлүүлсэн бөгөөд тайланг эцэслэж Засгийн газарт хугацаанд нь хүргүүлсэн.<br><br>**Үр нөлөө:** 6 төрлийн бодлогын баримт бичгийн тайланг хууль, журамд заасан хугацаанд хагас жил болон жилийн эцсийн байдлаар Засгийн газарт хүргүүлсэн. | 100 | |
| 5 | 18 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>**2021-12-17**<br>**Дугаар 2022.05.01** | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу аймгийн албан ёсны https://govisumber.gov.mn/ сайтад байгууллагын Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги зорилго, зорилт, тэргүүлэх чиглэл тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлын арга хэмжээг тухай бүр шинэчлэн оруулж ажиллаж байна. Мөн тус мэдээллийг байгууллагын 1 | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | давхар болон 3 давхарын мэдээллийн самбарт байршуулж иргэдэд ил тод мэдээлж байна.<br>https://govisumber.gov.mn/?page_id=318<br>https://govisumber.gov.mn/?cat=168 | | |
| | 19 | 8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | байгууллагын хаяг байршил, харилцах утас, нийгмийн сүлжээний хаягийг цахим хуудаст байршуулсан. Мөн байгууллагын бүтэц орон тоог нийтэд ил болгож нийтэлсэн. https://govisumber.gov.mn/?cat=94 | 100 | |
| | 20 | 8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Аймгийн Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг байгууллагын цахим хуудаст мэдээлсэн. 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлтыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансанд байршуулсан. https://govisumber.gov.mn/?cat=175<br>https://govisumber.gov.mn/?cat=260 | 100 | |
| | 21 | 8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | Аймгийн хэмжээнд хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан гардаггүй болно. | 100 | |
| | 22 | 8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө, тайлангуудыг аймгийн цахим хуудас https://govisumber.gov.mn/?cat=168 байршуулсан. | 100 | |
| | 23 | 8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй нийт 151 хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын жагсаалт, хөдөлмөрийн дотоод журмыг мэдээллийн самбар болон https://govisumber.gov.mn/?cat=95 цахим хуудсанд байршуулсан. Мөн эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn хуудсыг аймгийн албан ёсны цахим хуудастай холбосноор иргэд бусад хууль, тогтоомж, дүрэм журамтай танилцах боломжтой болсон. https://govisumber.gov.mn/?cat=269 | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 24 | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | Аймгийн цахим хуудасны ил тод байдал цэсийн хүний нөөцийн ил тод байдал хэсэгт байгууллагын албан хаагчдын мэдээлэл /албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг/, төрийн захиргааны 28 албан тушаалын тодорхойлолтыг https://govisumber.gov.mn/?page_id=356 https://govisumber.gov.mn/?cat=265 байршуулсан. | 100 | |
| | 25 | 8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 1, 2 дугаар улирлын тайлан, мэдээг цахим хуудаст болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан. https://govisumber.gov.mn/?cat=102 | 100 | |
| | 26 | 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | Хүн ам, мал, газар тариалан, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, эрүүл мэнд, гэмт хэрэг, боловсролын салбарын 12 төрлийн статистик мэдээллийг https://govisumber.gov.mn/?cat=256 аймгийн цахим хуудас болон фэйсбүүк хуудсаар иргэдэд тогтмол мэдээллэж байна. | 100 | |
| | 27 | 8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. | Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа томоохон арга хэмжээний мэдээллийг https://govisumber.gov.mn/?cat=1 цахим хуудсанд 49 видео мэдээ, 120 зурган мэдээ мэдээллийг тогтмол байршуулж байна. Мөн 7 хоног бүрийн тойм мэдээг видео шторк хэлбэрээр бэлтгэн албаны цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэдэд хүргэн ажиллаж байна. | 100 | |
| | 28 | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Аймгийн Засаг даргын Тамгын газраас 2023 онд 8 сул орон тоо гарсныг цахим хуудсанд байршуулан захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлснээс 4 сул орон тоо нөхөгдөөд байна. https://govisumber.gov.mn/?cat=128 Аймгийн хэмжээнд төрийн жинхэнэ албаны 90 сул орон тооны зарыг цахимаар хүргэн ажиллаж, хуулийн дагуу 22 сул орон тоо нөхөгдсөн. | 100 | |
| | 29 | 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам, Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журмууд болон аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/05 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-д албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах нөхцөлийг тусган | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | байгууллагын https://govisumber.gov.mn/?cat=263 цахим хуудсад байршуулсан. | | |
| | 30 | 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/08 дугаар тушаалаар байгууллагын ёс зүйн зөвлөлийг шинэчилж, 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан шийдвэр болон Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг https://govisumber.gov.mn/?cat=124 цахим хуудасны ил тод байдал цэсийн хүний нөөцийн ил тод байдал хэсэг, байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан. | 100 | |
| | 31 | 8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | Хүний нөөцийн стратегийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд АЗДТГ-ын “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”-ийг шинэчилж, АЗДТГ-ын даргын 2022 оны А/21 дүгээр тушаалаар батлуулан байгууллагын https://govisumber.gov.mn/?cat=116 цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. | 100 | |
| | 32 | 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Аймгийн цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал цэсэнд сул орон тоо, албан тушаалын тодорхойлолт, албан хаагчдын танилцуулга, АЗДТГ-ын “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”, байгууллагын ёс зүйн зөвлөлийн мэдээлэл, албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлж, дүгнэх журам болон гүйцэтгэлийн үнэлгээ зэрэг мэдээллүүдийг тогтмол байршуулж байна. https://govisumber.gov.mn/?cat=89 | 100 | |
| | 33 | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам, албан хаагчдыг үнэлсэн үнэлгээг https://govisumber.gov.mn/?cat=113 цахим хуудсанд байршуулсан. Мөн байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээг тусган цахим хуудсанд байршуулсан. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 34 | 8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | Аймгийн 2022 оны төсвийн гүйцэтгэл, 2023 оны батлагдсан төсвийг шилэн данс, мэдээллийн самбар, байгууллагын https://govisumber.gov.mn/?cat=34 цахим хуудсанд бүрэн байршуулсан. | 100 | |
| | 35 | 8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | Аймгийн 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан, 2023 оны хагас жилийн санхүүгийн нэгдсэн тайланг https://govisumber.gov.mn/?cat=29 аймгийн цахим хуудас болон шилэн данс, мэдээллийн самбарт тус тус мэдээлж ажилласан. | 100 | |
| | 36 | 8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хуулийн хугацаанд https://govisumber.gov.mn/?cat=137 аймгийн цахим хуудас болон шилэн дансанд бүрэн байршуулсан. 2022 оны санхүүгийн тайлан зөрчилгүй дүгнэгдсэн. | 100 | |
| | 37 | 8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар батлагдсан Үл хөдлөх хөрөнгийн хувь хэмжээ тогтоосон тогтоолыг https://www.shilendans.gov.mn/org/4416?group=0&year=2022 аймгийн цахим хуудас болон шилэн дансанд байршуулсан. | 100 | |
| | 38 | 8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | Сар бүрийн төсвийн хэтрэлт хэмнэлтийн мэдээллийг шилэн дансанд https://shilendans.gov.mn/organization/4579 бүрэн, хугацаанд нь байршуулсан. 2023 оны эхний хагас жилийн төсвийн төлөвлөгөө өссөн дүнгээр 13 611.1 сая төгрөг, гүйцэтгэл 06 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар 8,441.7 сая төгрөг бөгөөд одоогоор 5 169.4 сая төгрөгийн бодит бус хэмнэлттэй байна. | 100 | |
| | 39 | 8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг шилэн дансанд хуулийн хугацаанд оруулж, 2023 онд 27 удаагийн 194,454,124.00 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байдлыг шилэн дансанд байршуулсан. https://shilendans.gov.mn/organization/4579 | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 40 | 8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг шилэн дансанд хуулийн хугацаанд оруулж, 2023 онд 27 удаагийн 194,454,124.00 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байдлыг шилэн дансанд байршуулсан. https://shilendans.gov.mn/organization/4579 https://shilendans.gov.mn/org/4417?form=6269777&year=2022&month=12&group=1&task=1957 | 100 | |
| | 41 | 8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 11 дүгээр “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” тогтоол, мөн 2023 оны 02 дугаар сард төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан тухай 10 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх Арга хэмжээний зардлын төсөв, задаргаа баталсан захирамжуудыг байгууллагын цахим хуудас, шилэн данс, https://shilendans.gov.mn/org/4417?form=6307145&year=2022&month=12&group=2&task=1957 мэдээллийн самбарт байршуулсан. | 100 | |
| | 42 | 8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | Аймгийн 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу зөрчлийг арилгах, ажил сайжруулах төлөвлөгөө боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. | 30 | |
| | 43 | 8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | Байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй мэдээллийн Үнэлгээний хорооны зөвлөмж дүгнэлт, тайланг байршуулж захиалагчид хүргүүлж хэвшсэн. Мөн оролцогч нарт шалгарсан болон шалгараагүй үндэслэлийг хүргүүлэн ажиллаж байна. https://haaa.gs.gov.mn/ | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 44 | 8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт; | 2022 оны худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын цахим хуудас болон шилэн данс, мэдээллийн самбарт хуулийн хугацаанд бүрэн байршуулсан. https://haaa.gs.gov.mn/category/ | 100 | |
| | 45 | 8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | Баянтал, Шивээговь сумдын худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөлтөд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөгөө, зааварчилгаа өгч, зөвлөмжийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. https://govisumber.gov.mn/?cat=259 | 70 | |
| | 46 | 8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | Улсын болон орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар 8.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 25 төсөл арга хэмжээнээс 6.2 тэр бум төгрөгийн төсөвт өртөг бүхий 22 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнг www.tender.mn болон Орон нутгийн өмчийн газрын цахим хуудсанд бүрэн байршуулсан. | 100 | |
| | 47 | 8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | 3 байгууллагын 2018-2022 онд хийгдсэн 20 судалгааны тайланг https://sudalgaa.gov.mn/u/govisumber?id=true цахим системд оруулсан. | 100 | |
| | 48 | 8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | Аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоол, төсөвт зохицуулалт хийсэн тогтоол, аймгийн төсвийн нэмэлт, өөрчлөлт баталсан тогтоол, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн явц, үр дүн, авлигын эсрэг төлөвлөгөө, тайлан зэргийг https://shilendans.gov.mn/org/4417 https://shilendans.gov.mn/org/55?form=6020718&year=2022&month=8&group=1&task=13 Шилэн данс болон цахим хуудсанд бүрэн байршуулсан. | 100 | |
| | 49 | 8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | Аймгийн цахим хуудсанд Засаг даргын Тамгын газраас олгодог хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, архивын лавлагаа олгох журам дүрэм, бүрдүүлэх бичиг баримт, үйлчилгээний хөлс, төлбөр хураамж төлөх дансны мэдээллийг цахим хуудсанд байршуулсан. Мөн Архи худалдан борлуулах, ашигт малтмалын зөвшөөрөл, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр авах болон хугацааг сунгах үйлчилгээг e-mongolia.mn-д байршуулан цахимаар авах нөхцөлийг бүрдүүлсэн. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | https://govisumber.gov.mn/?cat=152 цахим хуудаст оруулж байршуулсан. | | |
| | 50 | 8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа. | Аймгийн Засаг даргаас олгогддог 3 төрлийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, шинээр олгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг аймгийн цахим хуудас govisumber.gov.mn-д байршуулж, цахимаар хүсэлт хүлээн авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацааг https://govisumber.gov.mn/?cat=157 https://govisumber.gov.mn/?cat=246 https://govisumber.gov.mn/?cat=152 аймгийн цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан. | 100 | |
| | 51 | 8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | Нээлттэй Говьсүмбэр хөтөлбөрийг боловсруулан иргэдийн саналыг авахаар цахим хуудаст байршуулсан. https://govisumber.gov.mn/?cat=269 Аймгийн хэмжээнд хэм хэмжээ тогтоосон 11 актыг мөрдөгдөн ажиллаж байна. https://govisumber.gov.mn/?cat=7 | 100 | |
| | 52 | 8.6.2. эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт; | Говьсүмбэр аймгийн хэмжээнд эзэмшиж буй оюуны өмчийн эрхийн жагсаалт иргэн байхгүй болно. | - | |
| | 53 | 8.6.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл; | Аймгийн хэмжээнд 2023 онд сумдын газар зохион байгуулалтын тухайн жилийн 3 төлөвлөгөөг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем /egazar.gov.mn/ болон сумдын цахим хуудас, аймгийн цахим хуудас https://egazar.gov.mn/plan/document/10187 оруулан иргэдэд ил тод нээлттэйгээр байршуулан ажиллаж байна. | 100 | |
| | 54 | 8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | Төсвийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудад чиглэл өгсний дагуу өөрийн эзэмшиж буй газрын мэдээллийг цахим хуудсанд байршуулсан. https://govisumber.gov.mn/?cat=141 | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 55 | 8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг; | Ус-ду ОНӨААТҮГазар нь usdu.water-mongolia.com цахим хуудас, Шивээ-Овоо ХК нь shivee-ovoo.mn цахим хуудсыг ажиллуулан байгууллагынхаа нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, санхүүгийн тайлан зэрэг мэдээллүүдийг цахим хуудсандаа байршуулсан. Тус цахим хуудсуудыг аймгийн цахим хуудастай холбон ажиллуулж байна. | 100 | |
| | 56 | 8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл; | Шивээ-Овоо ХК-ийн цахим хуудаст удирдах зөвлөлийн бүтэц, гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээллийг шинэчлэн цахим хуудсанд байршуулсан байна. | 100 | |
| | 57 | 8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; | Орон нутгийн өмчит 45 байгууллагын өмчийн хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээллийг Орон нутгийн өмчийн газрын www.Haaa.gs.gov.mn цахим хуудсанд цэс шинээр нээж, байршуулсан. Мөн аймгийн хэмжээнд төрийн албаны 41 орон сууцны түрээсийн гэрээ, орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн 17 түрээсийн гэрээг баталгаажуулж, түрээсийн орлогын төлөвлөгөөний нэгтгэл гарган, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж орлого 21.2 сая төгрөг буюу 85 хувийн гүйцэтгэлтэй байгааг байгууллагын сайтад сар бүр мэдээлэн | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажиллаж байна.Төрийн болон орон нутгийн өмчийн цахим хуудсуудыг аймгийн цахим хуудсанд холбон ажиллаж байна. | | |
| | 58 | 8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл; | Аймгийн Ус-Ду ОНӨААТҮГ-ын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг usdu.water-mongolia.com цахим хуудсанд байршуулсан. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 5 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 6 төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн. Үүнд: Шивээговь сумын ЗДТГ-аас “Нийтийн биеийн тамирын талбай байгуулах”, “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах” төсөл, иргэнээс “Бичиг хэргийн дэлгүүр” төсөл, Стандарт, хэмжил зүйн хэлтсээс “Хими, нян судлал, хорио цээрийн лаборатори” төсөл, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-иас “Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах” төсөл, иргэнээс “Шатахуун түгээх станц” төслүүдэд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж ерөнхий үнэлгээний дүгнэлтийг http://baigal.gs.gov.mn/?page_id=178 цахим хуудаст байршуулсан. | 100 | |
| | 59 | 8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт; | 2023 онд шинээр ашиглалтад орсон барилга байгууламж байхгүй болно. 2022 онд аймгийн Цагдаагийн хэлтсийн шинэ барилга, ЕБ-ын 2 дугаар сургууль, 5 дугаар цэцэрлэгийг ашиглалтад оруулсан бөгөөд улсын комиссын дүгнэлтийг https://govisumber.gazar.gov.mn/ Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын цахим хуудсанд байршуулсан. | 100 | |
| | 60 | 8.6.13. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ; | Орон нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа Шивээ овоо ХК нь Шивээговь сумын ЗДТГ-тай сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээг shiveegovi.gs.gov.mn цахим хуудаст байршуулан ажилласан. Шивээговь сумын цахим хуудсыг аймгийн цахим хуудастай холбосон. | 100 | |
| | 61 | 8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл; | Говьсүмбэр аймгийн 15 байгууллагын 61 үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монголиа системд нэвтрүүлсэн. Мөн egazar.gov.mn хуудсаар иргэд цахимаар үйлчлүүлж байна. Аймгийн | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | цахим хуудсанд И-Монголиа, egazar.gov.mn хуудасны линкийг холбосон. | | |
| | 62 | 8.6.21. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт; | Аймгийн Засаг даргын 2021 оны А/247 дугаар захирамжаар орон нутагт дутагдалтай мэргэжлээр суралцаж буй оюутанд “Аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг“ олгох журмыг батлан, хэрэгжүүлсэн. Тэтгэлгийг орон нутагт дутагдалтай мэргэжилээр суралцаж байгаа 10 оюутанд тус бүр 2 сая төгрөг олгож гэрээ байгуулсан байна. “Аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг“ олгох журам болон тэтгэлэгт хамрагдсан сурагчдын мэдээллийг аймгийн цахим болон пэйж хуудсуудад байршуулан, иргэд олон нийтэд мэдээлсэн. https://govisumber.gov.mn/?p=24712 https://govisumber.gov.mn/?cat=232 | 100 | |
| | 63 | 8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | Аймгийн цахим хуудас болон мэдээллийн самбарт аймгийн цаг үе, үйл явдлын мэдээ, гадаад, дотоод хамтын ажиллагаа, удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний дэг, үүрэг даалгавар, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, цахим видео мэдээ, мэдээлэл зэргийг тогтмол байршуулж байна. https://govisumber.gov.mn/?cat=11 https://govisumber.gov.mn/?cat=12 https://govisumber.gov.mn/?cat=13 | | |
| 6 | 64 | **Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2021-12-24 Дугаар 2021-12-24**<br><br>11.3. Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ. (11.2.Улсын Их | Аймгийн Засаг даргад чиг үүрэг болгосон хууль тогтоомжийг улирал болон сараар тайлагнаж Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим систем (www.unelgee.gov.mn)-д хугацаанд нь шивж оруулсан. 2023 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын хууль 7 хуулийн 66 заалт, УИХ-ын 2 тогтоолын 3 заалт, УИХ-ын байнгын хорооны 4 тогтоол 12 заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 5 зарлигийн 11 заалт, Үндэсний аюулгүй байдлын 3 зөвлөмжийн 4 заалт, Засгийн газрын 12 тогтоолын 19 заалт, Засгийн газрын хуралдааны 18 тэмдэглэлийн 20 заалт, Засгийн газрын 3 албан даалгаврын 5 заалт, нийт 54 шийдвэрийн 140 заалтыг хяналтад авч 87.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана.) | Үр нөлөө: Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 86.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна. | | |
| 7 | 65 | **Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-07-05 Дугаар 2023.01.01**<br><br>15.7. Согтууруулах ундаа худалдах, түгээгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны байршил, аймаг, нийслэлийн саналыг харгалзан хүнс, эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтооно. | Аймгийн хэмжээнд архи, согтруулах ундааны тусгай зөвшөөрөлтэй 45 цэг үйл ажиллагаа явуулж байна. Согтууруулах ундааны эргэлтэд хяналтад тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан тус хуулийн 15.7 дугаар зүйлийн согтууруулах ундаа худалдах, түгээгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тогтоох асуудал шийдвэрлэгдэх хүртэл хугацаанд аймгийн Засаг Даргын 2023 оны А/204 дугаар захирамжаар норматив батлагдах хүртэл дагаж мөрдөхөөр шийдвэрлэсний дагуу зөвхөн тусгай зөвшөөрөл сунгах хүсэлтийг хүлээн авч 10 аж ахуйн нэгжийн 9 хүсэлтийг журам батлагдах хүртэл хугацаагаар сунгасан. Нормавит шинэчлэгдэж батлагдсанаас хойш тусгай зөвшөөрөл шинээр хүссэн хүсэлтийг хүлээж авна.<br><br>**Үр нөлөө:** Тусгай зөвшөөрөл сунгасан аж ахуйн нэгжийн тоо-9<br><br>Тусгай зөвшөөрөлтэй нийт аж ахуйн нэгжийн тоо-45 | 70 | |
| | 66 | 23.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түгээгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно. | Аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/18 дугаар захирамжаар худалдаа үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарийг батлан мөрдүүлж, сумдын Засаг дарга, Цагдаагийн байгууллагатай хамтран хяналт тавин ажиллахад цагийн хязгаар зөрчиж үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж бүртгэгдээгүй болно. Мөн Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд хуулийн талаарх мэдээллийг хүргэж, цагийн хязгаарын талаарх саналыг авсан.<br>**Хүрсэн үр дүн:** | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Цагийн хязгаар зөрчиж үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж байхгүй. | | |
| **Хэсгийн дундаж: 93.13 хувь** | | | | | |
| УИХ-ын тогтоол | | | | | |
| 8 | 67 | **Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br><br>**2022-11-11**<br><br>**Дугаар 2022 №72**<br><br>1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах; | "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэлээр 2023 онд томоохон бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна. Үүнд: 2019 оны орон нутгийн хөрөнгөөр “Аймгийн төвийн үерийн хамгаалалтын суваг, ус зайлуулах систем”-ийн зураг төсвийг хийлгэсэн. Уг ажлыг гүйцэтгэх санхүүгийн эх үүсвэр шийдэгдээгүй. Аймгийн төвд “Юникл Таувэр” ХХК-тай гэрээ байгуулан 315 айлын, “Осо Констракшн” ХХК-тай гэрээ байгуулан 40 айлын, нийт 355 айлын орон сууцны барилга бариулах ажлыг гүйцэтгэж байна. 315 айлын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэл 10 хувь, 40 айлын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэл 45 хувьтай байна. Дээрх төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн улсын төсвийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гадна бохирын шугам, орон нутгийн 240.8 сая төгрөгөөр 6кв ЦДАШ, 2Х630 кВт-ын хаалттай дэд өртөөний ажлыг тус тус гүйцэтгэсэн. Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар улсын төсвийн 700.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сүмбэр сумын 1 дүгээр багийн 408 айл өрх, 70 аж ахуйн нэгж байгууллагыг бохирын төвлөрсөн бохирын шугамд холбох ажлыг “Мөнх Сүмбэр” ХХК гүйцэтгэж 2023 оны хагас жилийн байдлаар 75 хувьтай байна. 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 530 м цэвэр усны шугам татаж цэвэр усны худаг хийгдэхээр төлөвлөгдөн тендер шалгаруулалт зохион байгуулагдаж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн 95.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянтал сумын 75 айлын 154 дүгээр байрны зоорийн давхарын шугам засвар шинэчлэлийн ажлыг “Такамаса” ХХК гүйцэтгэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр ашиглалтад хүлээн авсан.<br><br>**Үр нөлөө:** "Шинэ сэргэлтийн бодлого", "Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан 6 зорилт, арга хэмжээний бэлтгэл | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажил бүрэн хийгдэж ажлын дундаж гүйцэтгэл 48.3 хувьтай хийгдэж байна. | | |
| | 68 | 1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; | 2023 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалт байхгүй болно. | 100 | |
| 9 | 69 | **Монгол улсын үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай**<br>**2023-05-05**<br>**Дугаар 2023 №37**<br><br>5. Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийг харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд хуульд заасан эрх хэмжээний хүрээнд зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй. | Монгол Улсын Засгийн Газраас санаачлан боловсруулсан Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзоригоор ахлуулсан ажлын хэсэг Говьсүмбэр аймагт 2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Монгол Улсын Үндсэн хуульд оруулж буй нэмэлт өөрчлөлтийг танилцуулж иргэдийн дунд санал асуулга явуулсан. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл нь дараах зорилготой явагдсан. Үүнд: Хүний эрхийн талаарх үндсэн хуулийн хамгаалалтыг бэхжүүлэх, ард түмнийг төлөөлөх парламентын чадавхийг сайжруулах, хөгжлийн олон төвтэй улс болох, 2019 оны нэмэлт, өөрчлөлтийг гүйцээх, оролцогчдоос үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналын хуудсыг цуглуулан авч ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.<br>**Үр нөлөө:** Хэлэлцүүлгийн арга хэмжээг бүрэн зохион байгуулсан. | 100 | |
| **Хэсгийн дундаж: 90.0 хувь** | | | | | |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | |
| 10 | 70 | “**Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай** | Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээг хөгжүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 5 чиглэлийн арга хэмжээнд 3577 иргэдийг хамруулан сургалт, зөвлөгөө нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан. Үүнд: “Гэр бүлийн боловсрол олгох” сургалтыг | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **2018-01-31**<br>**Дугаар 2018 №02 ХЗБХ**<br><br>3.8. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах. | төрийн албан хаагч нарт болон зорилтот өрхийн иргэдэд танхимаар 9 удаа зохион байгуулж 378 иргэн, “Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”-өөр дамжуулан анхан шатны ганцаарчилсан зөвлөгөө болон танхимын сургалтыг 405 иргэнд, “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан 2 суманд гэр бүлийн өдөрлөгийг зохион байгуулж 100 иргэнд гэр бүлийн харилцааны сургалт, орон нутагтаа үлгэр жишээ, манлайлагч, хөдөлмөрч 6 гэр бүлийг шалгаруулан, сурталчилсан. Мөн Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх хамгааллын зөрчлийн дуудлага мэдээллийн дагуу 8 удаагийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, анхан шатны сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл болон гэр бүлийн боловсрол олгох, гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар сургалтыг зохион байгуулсан. Эцэг эх, гэр бүлийн үүрэг хариуцлагыг нэмэдүүлэх, хууль эрх зүйн мэдээлэл, мэдлэгийг олгох чиглэлээр 699 иргэнд гэр бүлийн харилцаа хандлага, үүрэг хариуцлага, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн сургалт, мэдээлэл хүргэсэн.<br><br>**Үр нөлөө:** Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд нийт 3577 иргэдийг хамруулан 4.3 сая төгрөг зарцуулсан. | | |
| 11 | 71 | **Чиглэл өгөх тухай**<br>**2022-06-07**<br>**Дугаар 2022 №14 НББХ**<br><br>1.6/. Улсын хэмжээнд сум бүрийг “Ахмадын өргөө”-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх; | Сүмбэр суманд 2016 онд "Ахмадын өргөө"-г байгуулан, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангасан бөгөөд тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. 2023 онд Ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжин урсгал зардал, ахмадын урамшууллыг орон нутгийн төсөвт тусган 52.6 сая төгрөгийг батлуулан олгож байна. Мөн ахмадын өргөөний тохижилтын ажлыг хийж 8-р сард хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Баянтал, Шивээговь сумдад 2018 онд ахмадын өргөөг байгуулан одоог хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. Тус өргөөний урсгал засвар, тоног төхөөрөмжийг жил бүр сайжруулан ажиллаж 2023 онд Баянтал суманд 2.0 сая төгрөгөөр ширээ, сандалыг сайжруулсан. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | 72 | **Чиглэл өгөх тухай**<br>**2023-03-28**<br>**Дугаар 2023№05 НББХ**<br><br>1.1.4/. асрамж, халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллах орон тооны сэтгэл зүйч, дохионы хэлний хэлмэрч, сэтгэл засалчийг ажиллуулах, онлайнаар тус үйлчилгээг авах нөхцөлөөр хангах; | Дээд шатны байгууллагаас 20 бүтэц орон тоо батлагдсанаас хагас жилийн байдлаар 14 орон тоотойгоор ажиллаж байна. Түр хамгааалах байраар үйлчлүүлж буй 5 хүүхдэд нийгмийн ажилтан сэтгэлзүйн зөвлөгөө үзүүлэн ажиллаж байна. | 70 | |
| | 73 | 1.1.9/. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүүхдээс мэдүүлэг авахад зориулж тусгайлан бэлтгэсэн өрөө бий болгох, хүүхдийн эрхийг хамгаалсан бодлогыг хэрэгжүүлж ажиллах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа хохирогчтой ижил хүйсийн байцаагч ажиллуулах; | 3 сумын ЗДТГ-ын байранд хүүхдээс мэдүүлэг авах өрөөг байгуулан ажиллаж байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзуулах өрөөг тохижуулахад 6,945,000 төгрөгийн санхүүжилт олгож тогтвортой ажиллах нөхцөлөөр хангасан. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн төлөвлөгөөт хяналт шалгалтаар аймгийн бүх сургууль, цэцэрлэгийн “Хүүхэд хамгааллын бодлого”-ын хэрэгжилт, “Хүүхэд хамгааллын баг”-ийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхэддээ тавих хараа хяналтыг сайжруулах, асран хамгаалж, төлөвшүүлэх үүргээ биелүүлэх мөн хүүхдийн эрхийн зөрчил гарахад хэнд хандаж эрх зүйн туслалцаа авах талаар болон Хүүхэд хамгааллын захидлыг 800 гаруй эцэг эхэд хүргүүлсэн. “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлэхэд багш ажилтанд сахилгын зөрчил, захиргааны зөрчлийг оногдуулах, шалган шийдвэрлэх, шийтгэл ногдуулах, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтыг сургууль, цэцэрлэгийн нийт 337 багш, ажилчдад хүргэсэн. Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй болно.<br><br>**Үр нөлөө:** Хүүхдээс мэдүүлэг авах өрөөний тоо-Хяналт шалгалтад хамрагдсан сургууль, цэцэрлэгийн тоо-11 | 70 | |
| | 74 | 1.1.12/. “Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасан байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого | Боловсролын байгууллагад хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаарх хяналт шалгалтыг Боловсрол, Шинжлэх ухааны газар, сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран Хүүхэд хамгааллын бодлогын | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх заалтын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын бодлого, түүний боловсруулалтын талаар зөвлөмж гаргаж байгууллагуудад хүргүүлэх. | хэрэгжилт, Хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааны хэрэгжилт болон үдийн хоолны чанарын чиглэлээр 2, 4 дүгээр сард зохион байгуулж аймгийн хэмжээнд боловсролын үйлчилгээ эрхэлдэг 5 сургууль, 6 цэцэрлэг, 2 хүүхэд харах үйлчилгээний төв нийт 13 байгууллагад ажиллаж хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай 1 СӨБ-ийн байгууллагад хугацаатай албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилласан.<br><br>**Үр нөлөө:** Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлдэг байгууллагын тоо-13<br><br>Хяналт шалгалтын тоо-2<br><br>Зөвлөгөө, зөвлөмж өгсөн байгууллагын тоо-13 | | |
| | 75 | 1.2.1/. хүүхэд хөгжлийн чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр, Хүүхдийн урлан бүтээх төвийн барилга байгууламжийг шинэчлэх зардлыг улсын төсөвт шат дараатай тусгаж, шийдвэрлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг бүсчилсэн хэлбэрээр ажиллуулах, хүүхдийн хөгжил төлөвшилд хүрч үйлчлэх нөхцөл бүрдүүлэх; | Хүүхдийн ордон барих газрын асуудлыг шийдвэрлэн, барилгын ажлын зураг төсвийг хийлгэсэн. 2024 оны улсын төсөвт “Хүүхдийн ордон” барихад шаардагдах 4,525,123,478.00 төгрөгийг тусгахаар саналыг улсын төсөвт хүргүүлсэн. | 30 | |
| | 76 | 1.2.2/. цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, залилах, хүчирхийлэлд уриалах, садар самуун явдлыг сурталчлах зэрэг гэмт хэрэг, зөрчлийн үйлдлүүдийг таслан зогсоох, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн яаралтай авах; | Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдын ерөнхий боловсролын сургуулиудын ахлах, дунд ангийн нийт 833 хүүхдэд үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх болон цахим зохистой хэрэглээний сургалтыг зохион байгуулсанаар боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт сайжирч, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаа эрчимжиж, хүүхдийг аливаа төрлийн хүчирхийллээс ангид байлгах, хамгаалах, нөхөн сэргээх, хөгжүүлэхэд чиглэсэн мэдлэг ойлголт нэмэгдсэн байна. тус үйл ажиллагаанд 3.900.000 төгрөг зарцуулсан. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | **Үр нөлөө:** Цахим орчинд хүүхдийн хүүхдийн нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, залилах, хүчирхийлэлд уриалах, садар самуун явдлыг сурталчлах зэрэг гэмт хэрэг, зөрчил аймгийн хэмжээнд бүртгэгдээгүй болно. | | |
| | 77 | 1.2.4/. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016-2022 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх, жил бүр хөндлөнгийн хяналт оруулах; | Жил бүр аймгийн Төрийн аудитын газраас Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэж байна. 2022 оны санхүүгийн үйл ажиллагааны аудитаар зөрчилгүй дүгнэгдсэн. Хөндлөнгийн аудит ороогүй болно.<br><br>**Үр нөлөө:** 2022 оны санхүүгийн үйл ажиллагааны аудитаар зөрчилгүй дүгнэгдсэн. | 70 | |
| | 78 | 1.2.6/. Хүүхдийн эрхийн байцаагчийн чиг үүргийг боловсронгуй болгох, нийгэмд таниулах ажлыг эхлүүлэх. | Хүүхдийн эрхийн байцаагчийн албан тушаалын тодорхойлолтод чиг үүргийг тодорхой тусган дээд шатны байгууллагаар батлуулан тус чиг үүргийг жил бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br><br>**Үр нөлөө:** Албан тушаалын тодорхойлолтыг батлуулан ажиллаж байна. | 70 | |
| 13 | 79 | **Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>**2023-04-25**<br>**Дугаар 2023 №05 ТБХ**<br><br>6в/. төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төсөв боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангах аргуудыг туршилтын журмаар нэвтрүүлэх, Төсвийн ил тод байдлын олон улсын санаачилга /С1оЬа1 1пШайуе Тог Е\|вса1 Тгалзрагелсу/ байгууллагаас гаргасан төсвийн бодлого боловсруулахад олон нийтийн оролцоог хангах зарчмуудыг | Төсөв боловсруулах үйл явц болон төсөв, санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоол, Аймаг, сумдын 2023 оны төсвийн мэдээлэлд үндэслэн “Иргэдийн төсөв-2023” эмхэтгэлийг бэлтгэн цахим хуудсанд байршуулсан. Тус мэдээлэлд батлагдсан орлого, зарлага, урсгал зардал, хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэхээр төлөвлөгдсөн ажлуудыг салбараар бүлэглэн танилцуулах зэргээр ойлгомжтой байдлаар мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн.<br><br>**Үр нөлөө:** “Иргэдийн төсөв-2023” эмхэтгэлийг бэлтгэн иргэдэд хүргэсэн. | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нэвтрүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны олон сувгаар дамжуулан төсвийн төслийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний санал бодлоо илэрхийлэх боломжийг олгох; | | | |
| | 80 | 6г/. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах. | Төсвийн үе шат бүрт мэргэжлийн судлаач, ТББ-ууд хамтран ажиллах, мэдээ, мэдээлэл иргэдэд ойлгомжтойгоор хүргэх зэрэгт үйл ажиллагаанд хамтран ажиллах боломжтой талаар иргэдэд хүргэн ажилласан. | 30 | |
| | 81 | 5а/. аймгуудын өрсөлдөх чадварын индексийг тогтоох аргачлалыг боловсруулан баталж, мөрдүүлэх, жил бүр Засгийн газраас Засаг дарга нартай байгуулдаг үр дүнгийн гэрээнд индексийг тусган, биелэлтийг хянах; | Өрсөлдөх чадварын судалгааны төвийн судалгаагаар 2022 оны үр дүнгээр манай аймаг 21 аймгаас өрсөлдөх чадвараараа 5 дугаарт эрэмбэлэгдсэн. Монгол Улсын Засгийн газраас өрсөлдөх чадварын индекс тогтоох аргачлалыг батлаагүй байна. | ҮБ | |
| **Хэсгийн дундаж: 73.64 хувь** | | | | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | |
| 14 | 82 | **Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46**<br><br>3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх | 2022 онд шинээр 10 байгууллага гадна, дотор хаягаа хос бичгээр хаягжуулсанаар нийт төрийн 63, хувийн хэвшлийн 19 байгууллага хаягаа хос бичгээр сольж, төрийн байгууллагын гадна хаягжуулалт 94 хувьд хүрсэн байна. Хэлний бодлогын Үндэсний зөвлөл, Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран 2 удаагийн сургалтаар монгол бичгээр албан бичгийг хэрхэн хослуулан хэрэглэх талаар мэдээлэл өгч, 148 төрийн албан хаагчдыг хамруулан мэдлэг олгосон.<br>МУ-ын Гавьяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит “Монгол бичиг мину” XX олимпиадын Бичвэр, бүтээлийн төрөл 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 05 дугаар сарын 23-ныг хүртэл хугацаанд 4 ангилалаар зарлан, зохион байгуулсан. Тус төрөлд Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллеж, Ерөнхий боловсролын сургуулийн 580 сурагчид, 45 багш, төрийн 12 байгууллагын 125 албан хаагч, иргэд оролцож, монгол бичгийн мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн. Мөн 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдөр "Номын соёлт ертөнц" төрийн бус байгууллагатай хамтран 45 зохиолчид, яруу найрагчид, хэвлэлийн компаниуд, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг орон нутагтаа урьж, | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Оюунлаг гэр бүл, Цахим бичвэрийн уралдаан, Үлгэрээс үлгэрлэе чанга уншлага, Уншаад урагшлахуй, Номын эзэн зэрэг 5 арга хэмжээ зохион байгуулж 1386 иргэдийг хамрууллаа.<br>**Үр нөлөө**: Зохион байгуулсан арга хэмжээний тоо-6, хамрагдсан иргэдийн тоо-2136, Зохион байгуулсан сургалтын тоо-2, хамрагдсан төрийн албан хаагчдын тоо-148 | | |
| 15 | 83 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>**2019-05-30**<br>**Дугаар 2019_104**<br><br>1.16. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих. | Ерөнхий боловсролын 5 сургуулийн буфет, сургууль орчны 4 дэлгүүрт хяналт тавьж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, хугацаатай 2 зөвлөмжийг хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажилласан. Мөн аймгийн Засаг даргын орлогч даргаар батлуулсан удирдамжийн дагуу 5 байгууллагын хамтарсан хяналт шалгалтыг 2023 оны 02, 04 дүгээр сард зохион байгуулж 6 цэцэрлэг, Ерөнхий боловсролын 5 сургууль, Политехник коллеж, 2 хүүхэд харах үйлчилгээг хамруулан цэцэрлэгийн болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэл, үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилт, хүүхдийн дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээний явцад хяналт тавьж 13 байгууллагад зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>Үр нөлөө: Хяналт шалгалтын тоо-3<br>Хамрагдсан байгууллагын тоо-22<br>Зөвлөмжийн хэрэгжилт-70 хувь | 100 | |
| 16 | 84 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/**<br>**2021-10-04**<br>**Дугаар 2021_58**<br><br>1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг | Орон нутгийн уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 198.5 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас 149.3 сая.төг, Улсын төсвөөс 253.7 сая.төгрөг нийт 601.5 сая төгрөгийг батлуулсанаар аймгийн нийт төсвийн 2 хувийг эзлэж байна. Үүний дагуу Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 7 арга хэмжээг төлөвлөн 15 га ойн зурвас, 13 га талбайн байгалийн сэргэн ургалт, мод үржүүлгийн газрын тарьц суулгацын нөөцийг бүрдүүлэлт зэрэг үйл ажиллагааг зохион байгуулаад байна. Энэ жил 80.000 мод тарихаас 49.000 мод шинээр тарьж талбайн хэмжээг 25 га-аар нэмэгдүүлсэн. Мөн ногоон байгууламжийн усалгаа арчилгааг нэмэгдүүлэхээр ОНХС-ийн 112.5 сая төгрөгийн хөрөнгөөр гүний 1 худаг гаргуулах ажил 70 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.<br>**Үр нөлөө:** Улсын төсөвт 253.7 сая төгрөг, Орон нутгийн төсөвт 347.8 сая.төгрөг нийт 601.5 сая төгрөгийг батлуулсанаар аймгийн нийт төсвийн 2 хувийг эзэлж байна. | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах. | | | |
| | 85 | 1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох. | 2023 оны эхний хагас жилийн байдлаар Сүмбэр сумын "Ойн анги"-ийн 7 га талбайд 25000 ширхэг мод бут, сөөг шинээр тарьж усалгаа арчилгааг хийж байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах идэвхийг нэмэгдүүлэх сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлууд зохион байгуулсан. Үүнд: Япон улсад бүртгэлтэй "Монголын экологийн мэдээллийн төв" ТББ-тай хамтран Мод тарих технологи сэдэвт практик сургалтад ЕБС-ийн Эко бүлгийн 18 сурагч, Политехникийн коллежийн 21 оюутан, 14 байгууллагын 32 албан хаагч нийт 71 иргэнийг хамруулсан. Мөн JCI Олон Улсын байгууллагаас ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад экологийн боловсрол олгох чиглэлээр сургалт зохион байгуулж 150 сурагч хамрагдсан. Мод, бут тарих, усалгаа арчилгаа хийх, хог хаягдал ангилан ялгах талаарх "Эко өртөө" сургалтад 667 иргэн, ААНБ-ын албан хаагчдыг хамруулсанаар 1996, 1983 оны төгсөгчид нийт 495 мод тарьж, 2 байгууллага 50500 мөчир, суулгац хандивласан байна.<br><br>**Үр нөлөө:** Иргэдэд зохион байгуулсан сургалтын тоо-4, Сургалтад хамрагдсан иргэний тоо-888 | 70 | |
| | 86 | 1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах. | Ногоон байгууламжийн усалгаа арчилгааг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн 112.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүн өрмийн 1 худаг гаргах, хашаа барих ажлын тендерт "Ус ундрах" ХХК шалгарч гэрээ байгуулан ажлын гүйцэтгэл 70 хувьтай хийгдэж байна. Тус худгийг гаргаснаар 30 га талбайн ногоон байгууламжийн усалгааны асуудал шийдвэрлэгдэнэ. Мөн Улсын төсвийн 105.0 сая төгрөгийн хөрөнгөөр Баянтал сумын нутагт байрлах 10 га тайлбайн нөгөөн байгууламжид дуслын услалтын систем байршуулах ажил хийгдэж байна. | 30 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 87 | 1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх. | Цөлжилтөөс хамгаалах ганд тэсвэртэй, модлог ургамал тарималжуулж турших зорилгоор олон хувилбарт туршилт судалгааны ажлуудыг 2019 оноос явуулж байна. 2020 оноос хойш туршилтын 1-р талбайд 11 эгнээнд 550, салхинаас хамгаалах ойн зурваст 100, нийт 650 жигд, хармаг, монгол азар, сухай, заг зэрэг төрөл зүйлийн суулгац, туршилтын 2-р талбайд 600 мод сөөгний суулгац, 1000 улиас, 2023 оны харганы тарилт хийсэн. Туршилтаас гарсан 2000 тарьц, суулгацыг ойн зурваст тарьсан. Төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төлөвлөлтийн дагуу 2023 онд 7 га газарт мод бут тарьсан. Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд 87 га газарт ногоон байгууламж байгуулахаар тусгагдсан.<br><br>**Үр нөлөө:** Гандуу бүс нутагт мод сөөг тарих арга зүйн зөвлөмж боловсруулагдсан. Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд 87 га газарт ногоон байгууламж байгуулахаар тусгагдсан. | 100 | |
| | 88 | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах чиглэлээр иргэдийн дунд “Эх нутгийнхаа ногоон ирээдүйн төлөө хамтдаа”, “Мод тарьж ургуулъя” зэрэг уриалга гарган 2 шторк, 3 постерыг бэлтгэн иргэдэд цахимаар хүргүүлсэнээр 2000 гаруй иргэн нэгдсэн байна. Мөн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны 11 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар мод, сөөгний урамшуулалд 49.9 сая төгрөгийг олгохоор батлуулсан. Өөрийн хөрөнгөөр эзэмшил газрынхаа 20 хувьд мод бут тарьж ургуулсан иргэн, ААНБ-ыг урамшуулах ажил 10 дугаар сард зохион байгуулагдана. | 70 | |
| 17 | 89 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>**2022-04-05**<br>**Дугаар 2022_43**<br><br>1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг | Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/73 дугаар захирамжаар “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээ”-ний хүрээнд хагас жилийн байдлаар нийтийн биеийн тамирын 2, спортын 5, олимпизмын 1 арга хэмжээг тус тус зохион байгуулан, 5442 иргэдийг хамруулан, 30.1 сая төгрөгийг зарцуулаад байна.<br><br>Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багт спортын 10 төрлийн 207 тамирчин хамрагдан бэлтгэл сургуулилтаа хангаж, бүс болон Улсын аварга шалгаруулах тэмцээн, Хүүхдийн спортын 7 дугаар | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах; | наадам зэрэгт нийт 18 тэмцээн уралдаанд оролцоход дэмжлэг үзүүлэн, аймгийн ОНХС-ийн 25.0 сая төгрөгийг зарцуулаад байна<br>Спортын болон иог, спиннинг, бодибилдинг, фитнесс, аэробэк, спорт бүжгийн чиглэлээр сургалт, үйл ажиллагаа явуулдаг нийт 24 төрийн бус байгууллага, клубтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, нийтийг хамарсан 14 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлж, 23.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Өсвөрийн шигшээ багийн тамирчид спортын 12 төрөлд 47 хүрэл, 36 мөнгө, 21 алт нийт 104 медаль хүртээд байна.<br>**Үр нөлөө:** Орон нутагт биеийн тамир, спорт, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулдаг 24 төрийн бус байгууллага, клубтэй гэрээ байгуулан, олон нийтийг хамарсан 14 арга хэмжээг зохион байгуулж 78.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна. | | |
| 18 | 90 | **Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай**<br>**2022-07-11**<br>**Дугаар 2022_159**<br>2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай. | Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв ээе сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулах зорилгоор төрийн 60 байгууллагад үүрэг чиглэл өгч, сурталчлан таниулснаар 2023 оны хагас жилийн байдлаар нийт 35 байгууллага эш хөргийг залсан байна.<br>**Үр нөлөө:** Эзэн Богд Чингис хааны эш хөргийг төрийн 35 байгууллага дээдлэн залсан байна. | 70 | |
| | 91 | 3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай. | Сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэх чиглэлээр иргэдэд мэдлэг олгох сургалтыг төрийн 11 байгууллагын 196 албан хаагчдад зохион байгуулж, уриалга бүхий шторк мэдээг бэлтгэж, Говьсүмбэр аймгийн Соёл, урлагийн газар пэйж хуудас, Боржигин нутаг зарын хуудсуудаар сурталчилан иргэдэд түгээсэнээр 421 иргэн хандалт хийсэн байна. Мөн төрийн байгууллагууд албан хаагчиддаа | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 92 | | уриалсанаар төрийн 10 байгууллагын 40 гаруй албан хаагч Эзэн Богд Чингис хааны эш хөргийг гэртээ эрхэмлэн залсан байна.<br>**Үр нөлөө:** Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсан уриалгын тоо-1<br>Эзэн Богд Чингис хааны эш хөргийг гэртээ залсан албан хаагчдын тоо-40 | | |
| | 92 | 4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв ээе сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | Аймгийн Соёл урлагийн газраас Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээх зорилгын хүрээнд Сүмбэр сумын хөдөөгийн багийн 153 иргэнд уриалга, мэдээлэл өгч ажилласан. | 30 | |
| **Хэсгийн дундаж: 70.91 хувь** | | | | | |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | |
| 19 | 93 | **Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай**<br>**2010-03-18**<br>**Дугаар 2010_10/09**<br>1. Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх, | Говьсүмбэр аймагт ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламж байхгүй бөгөөд аймгийн хэмжээнд нийт 27 барилга байгууламжийг паспортжуулж Сүмбэрийн сумын 1-р багт 3.8 га газарт дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэхээр “Жаргалант хийц” ХХК иар зураг төсвийн ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан 90 хувьтай ажиллаж байна | 100 | |
| | 94 | 3. Газар хөдлөлтийн аюул, гамшигтай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг | Жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх долоо хоногийн Лхагва гарагт “Газар хөдлөлтийн гамшгийг таниулах өдөр”, Пүрэв гарагт “Гамшгийн зарлан мэдээллийн дохиогоор ажиллах” дадлага сургуулийг орон даяар | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | улсын хэмжээнд байнга, тогтмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооодог байх, | тогтмол зохион байгуулан ажиллаж байна. 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр газар хөдлөлтийн гамшгийг таниулах өдрийн хүрээнд Гамшгийн зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуульд 70 аж ахуй нэгж, байгууллагын 5790 иргэн, алба хаагчдыг хамруулсан. Мөн Монгол Улсын хэмжээнд стратегийн команд штабын сургуулийг 2023 оны 6 дугаар сарын 7-9-ний өдрийн хооронд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br><br>**Үр нөлөө:** Газар хөдлөлтийн аюул, гамшигтай тэмцэх мэдлэг чадвар дадал эзэмшүүлэх сургалтын тоо-2 хамрагдсан иргэдийн тоо - 5790. | | |
| 20 | 95 | **Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай**<br>**2019-12-31**<br>**Дугаар 2019_60/40**<br><br>2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвлшүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих. | Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын тоолууржуулалтын байдалд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд 117 аж ахуйн нэгж, байгууллага, 2673 айл өрх тоолуур суурилуулсан байна. Томоохон ус ашиглагч болох “Шивээ Овоо” ХК, “Эм Си Ти Ти” ХХК-ийн ус ашиглалтын байдалд хяналт тавих зорилгоор ашиглалтын худгуудад лац тавьж сар бүр тоолуурын заалтыг баталгаажуулж байна. “Шинэ Монгол Магнетит” ХХК-ийн магнетит боловсруулах үйлдвэр нь ашигласан усны 98 хувийг үйл ажиллагаандаа дахин ашиглаж байна.<br><br>**Үр нөлөө:** 117 аж ахуйн нэгж, байгууллага, 2673 айл өрх бүрэн тоолууржуулсан. 1 компани үйл ажиллагаандаа саарал усыг дахин ашиглаж байна. | 100 | |
| 21 | 96 | **"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2021-09-30**<br>**Дугаар 2021_03**<br><br>3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг | Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг иргэдэд хүргэх ажлын хүрээнд дараах ажлыг зохион байгуулсан. Үүнд: Япон улсад бүртгэлтэй “Монголын экологийн мэдээллийн төв” ТББ-тай хамтран Мод тарих технологи сэдэвт практик сургалтад-71, Булган голын алим ХХК-тай хамтран Алимны мод тарих, арчлах сургалтад-33, JCI Олон Улсын байгууллагаас ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад экологийн боловсрол олгох сургалтад 150 сурагч, мод, бут тарих, усалгаа арчилгаа хийх, хог хаягдал ангилан ялгах талаарх “Эко өртөө” сургалтад 667 иргэн, ААНБ-ын албан хаагчид нийт 4 удаагийн сургалтад 921 иргэнийг хамруулж 360 гарын авлага олгон ажилласан. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах. | Мөн цахимаар 2 шторк, 3 постер, 49 видео, заавар зөвлөгөө, 2 уриалгыг 2000 гаруй иргэнд хүргэн ажилласан байна. Радио нэвтрүүлэг 2 /Монголын үндэсний радио/, Орон нутгийн телевизэд 5 мэдээллийг иргэдэд хүгэсэн.<br>**Үр нөлөө:** Иргэдийн идэвхи оролцоо нэмэгдсэн. /1996, 1983 оны төгсөлт нийт 495 мод тарьсан. /2 байгууллага 50500 мөчир, суулгац хандивласан. | | |
| **Хэсгийн дундаж: 100 хувь** | | | | | |
| ЗГ-ын тогтоол | | | | | |
| 22 | 97 | **Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай**<br>**2022-04-06**<br>**Дугаар 2022_139**<br><br>1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх” богино хугацааны сургалтыг олон улсын тэргүүлэх шинэ дэвшилтэт арга хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т болон Засгийн газрын холбогдох гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан 3 удаагийн сургалтад 113 албан хаагчийг танхимаар хамрагдаж, цахимаар 424 албан хаагч хамрагдаж сертификат авсан. Үүнд: 2023 оны 01-р сард Удирдлагын академиас зохион байгуулсан Орон нутаг дахь төрийн албан хаагчдад зориулсан “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, түүний эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд богино хугацааны сургалтын сургагч багш бэлтгэх сургалтад 3 албан хаагч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2023 оны 02-р сард “Шилжилт хөдөлгөөн” сургагч багш бэлтгэх сургалтад 2 албан хаагч, Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд цахим болон танхимаар зохион байгуулж 46 байгууллагын 108 албан хаагч хамрагдаж сертификат авсан. Мөн тус цахим сургалтад 19 байгууллагын 1012 албан хаагчийг хамруулсан. “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нээлттэй Говьсүмбэр хэлэлцүүлгийг 2023 оны 01 сарын 16-ны өдөр зохион байгуулж Батлан хамгаалах яамны дэд сайд болон Шинэ сэргэлтийн бодлогын ажлын төлөөлөгч нар мэдээлэл хийж иргэдийн санал хүсэлтийг сонсож ажилласан. Хэлэлцүүлэгт агентлагийн дарга нар болон шилжин ирсэн иргэдийн төлөөллийг оролцуулсан 50 гаруй иргэд хамрагдсан. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | **Үр нөлөө:** "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын талаар зохион байгуулсан сургалтын тоо-3, хамрагдсан албан хаагчдын тоо-537 | | |
| 23 | 98 | **Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>**2022-05-25**<br>**Дугаар 2022_204**<br><br>9. Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | Төсвийн ерөнхийлөн захирагч нар дагаж мөрдөхөөр “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах журам”-ыг боловсруулан Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/179 дугаар захирамжаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Автомамашины хэрэглээг хязгаарласантай холбоотой орон нутгийн өмчит 43 байгууллагын 46 автомашины судалгааг гаргасан. Үүнээс автотээврийн хэрэгсэл ашиглах эрхтэй эрх бүхий албан тушаалтаны 4 автомашин, үндсэн үйл ажиллагаа нь автотээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ шаардлагатай 16 байгууллагын 33 автомашин, татан төвлөрүүлэх 8 байгууллагын 9 автомашинаас 1 авто машиныг шилжүүлж, 8 авто машиныг дуудлага худалдаанд оруулахаар төвлөрүүлээд байна. Автомашин төвлөрүүлэн, шилжүүлэхтэй холбоотой жолооч ажилгүй болсон тохиолдол гараагүй болно.<br>**Үр нөлөө:** Автомашин төвлөрүүлэн, шилжүүлэхтэй холбоотой жолооч ажилгүй болсон тохиолдол гараагүй байна. | 100 | |
| 24 | 99 | **Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2022-11-09**<br>**Дугаар 2022_402**<br><br>1.3. цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч | 2023 оны эхний хагас жилийн байдлаар орон сууцны хороолол, цогцолборын барилгын зураг төсөл батлагдаагүй байна. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | |
| | 100 | 1.4. орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, салбар бүлэг ажиллуулахад норм нормативыг мөрдүүлэх чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг авч, хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Аймгийн хэмжээнд СӨБ-ын 6 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаагаас 4 цэцэрлэг стандарт шаардлага хангасан байранд үйл ажиллагаагаа явуулж, Баянтал сумын СӨБ-ын цэцэрлэг нь сумын Засаг даргын Тамгын газрын байранд, Шивээговь сумын СӨБ-ын 9 бүлгээс 3 бүлэг нь ШОХК-ийн орон сууцны байрны 1 давхарт байрлаж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд стандартыг хангаж ажиллаж байна. Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөлийн барилга ашиглалтад орсноор 2 гэр цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосон. **Үр нөлөө:** Стандарт шаардлага хангасан цэцэрлэгийн тоо-6 | 100 | |
| | 101 | 2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай: 2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.2. орон сууцны хороолол, цогцолбор барилгад төлөвлөгдсөн цэцэрлэгийн барилгыг бүрэн ашиглалтад | Барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгаварт тусган ажиллаж байна. 2022 онд орон нутгийн хөгжил сангийн 25,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүмбэр сумын 4-р баг, /Тэрэгт/-т шинэ суурьшлын бүсийн төлөвлөлтийг хийхээр тендер шалгаруулалтыг зарлан "Перпект солюшн энд инженеринг" ХХК шалгарч, ажлын гүйцэтгэл 70 хувьтай хийгдэж байна. Дээрх төлөвлөлтөд цэцэрлэгийн барилгыг тусган төлөвлөсөн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг "Түмэн Алт" ХХК 75 хувийн гүйцэтгэлтэй, Шивээговь сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажлыг "Монничи кон трейд" ХХК 35 хувьтай гүйцэтгэж байна.<br><br>Барилга угсралтын явцад түр цэцэрлэг байгуулан ажиллуулсан тохиолдол байхгүй болно. | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | орох хүртэл хугацаанд тухайн бүс нутгийн байршилд “түр цэцэрлэг” байгуулан ажиллуулж байх талаар хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | **Үр нөлөө:** Суурьшлын бүсийн төлөвлөлтөд цэцэрлэгийн барилгыг тусгасан. Түр цэцэрлэг байгуулан ажиллуулсан тохиолдол байхгүй болно. | | |
| | 102 | 3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд 4 байршилд цэцэрлэгийн барилгыг тусгасан байна.<br><br>Төлөвлөгөөнд тусгагдсан байршилд газар олголт хийгдээгүй болно.<br><br>**Үр нөлөө:** Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд 4 байршилд цэцэрлэгийн барилгыг тусгасан байна. | 100 | |
| | 103 | 4. Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх, худалдан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, шаардагдах зардлыг жил бүрийн улс, нийслэл, орон нутгийн төсвийн төсөлд тусгахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг түрээслэх, худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулаагүй болно. | 100 | |
| 25 | 104 | **Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419**<br><br>3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан | Аймгийн Засаг даргын 2022 оны А/293 дугаар захирамжаар “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт ИТХ-ын 2023 оны 05 дугаар тогтоолоор, 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд ИТХ-ын 2023 оны 06 дугаар тогтоолоор тус тус нэмэлт өөрчлөлт оруулан батлуулсан. Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 11 дүгээр тогтоолоор "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэхэд 185.0 сая төгрөгийн зардлыг 2023 оны аймгийн төсөвт тусган батлуулсан. | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./ | (Шилжин ирсэн албан хаагчдад дэмжлэг үзүүлэх 150.0 сая, Шинэ сэргэлтийн бодлогыг сурталчлах арга хэмжээ 35.0 сая)<br><br>Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичгээс орон нутагт хамааралтай 14 зорилтын 31 арга хэмжээг хяналтанд авч 2022 оны жилийн эцсийн байдлаар 88.3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан. 2023 оны тайлан жилийн эцсээр гарна.<br><br>“Нээлттэй Говьсүмбэр” хөтөлбөрийг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 15 дугаар хуралдааны 2023 оны 04 дүгээр тогтоолоор батлуулан мөрдөн ажиллаж байна. Хөтөлөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй хөрөнгө оруулалтын уулзалтыг 04 дүгээр сарын 21-нд зохион байгуулж 50 гаруй аж ахуй нэгжийг урилгаар оролцуулж 17 аж ахуйн нэгжтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан. Мөн гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор аймагт үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалтай хувь эзэмшигч компаниудтай уулзалтыг зохион байгуулсан. Улаанбаатар хотоос болон бусад аймаг сумаас манай орон нутагт ажиллаж байгаа иргэдийн амьдрах нөхцөл болон орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуй нэгжийг дэмжиж ажиллах хүрээнд дараах бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд “ОСО констракшн” ХХК, “Юникл тауэр” ХХК-тай тус тус гэрээ байгуулан 347 айлын орон сууц барих ажлыг эхлүүлсэн. “ОСО констракшн” ХХК Сүмбэр сумын Найрамдал хотхонд 40 айлын орон сууцны барилгын ажлыг гүйцэтгэн 1, 2 дугаар давхрын цутгамал бетон, каркасыг хийж ажлын гүйцэтгэл 45 хувьтай байна.<br><br>**Үр нөлөө**: Аймгийн Засаг даргын 2022 оны А/293 дугаар захирамжаар “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулагдсан.<br><br>Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсвөөс 185 сая төгрөгийг батлуулсан. | | |
| | 105 | 4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой | Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд тус байгууллагтай холбоотой | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | нийт 8 заалтыг хяналтанд авч төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн “Шинэ сэргэлт, хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд “Нээлттэй Говьсүмбэр хөтөлбөр болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулан Аймгийн ИТХ-ын 04, 05 дугаар тогтоолоор батлуулан мөрдөн ажиллаж байна. Тус хөтөлбөртэй уялдуулан шилжилт хөдөлгөөний бодлого зохицуулалт, төрийн үйлчилгээ сэдвээр төрийн байгууллагын дарга, мэргэжилтнүүдийг хамруулсан сургалтыг 03 сарын 20-ны өдөр зохион байгуулж 97 албан тушаалтныг хамруулсан. 2023 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотоос 77 иргэн манай аймагт шилжин ирсэн байна. Үүнд том хүн 43, хүүхэд 34 байна. Улаанбаатар хотоос шилжин ирсэн иргэдэд орон нутгаас ажлын байраар хангах, орон байрны хөнгөлөлт үзүүлэх, үйл ажиллагаа эрхэлдэг бол хөнгөлөлттэй зээлд хамруулах зэрэг үйлчилээг үзүүлж байна.<br><br>**Үр нөлөө:** Улаанбаатар хотоос 77 иргэн шилжин ирсэн байна. | | |
| 26 | 106 | **Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2022-12-07**<br>**Дугаар 2022_448**<br><br>1.12. гүйцэтгэсэн ажлын бүтээмжийг нь харгалзан аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг хоёр дахин хүртэл нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож, орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.13.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль | 1.12. Аймгийн 2023 оны төсөвт Төрийн захиргааны албан хаагчийн орон нутагт ажилласны нэмэгдлийг 100 хувь, төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 26 хувиар тус тус нэмэгдүүлэн 1319.7 сая төгрөгийг батлуулан олгож байна.<br><br>1.13. Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн санг журмын дагуу төлөвлөн батлуулсан. Үүнд: Аймгийн орон нутгийн хөгжлийн санд 3,978,893.5 мян.төгрөг, Сүмбэр сумын ОНХСанд 1,224,792.7 мян.төг, Шивээговь сумын ОНХСанд 979,431.7 мян.төг, Баянтал сумын ОНХСанд 329,848.4 мян.төгрөг тус тус батлагдсан ба хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлж байна. Аймгийн 2022 оны ОНХС-ийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар “Зөрчилгүй” дүгнэгдсэн. Аймгийн Орон нутгийн хөгжил сан 2341.3 сая төгрөг 22 арга хэмжээ, хөрөнгө оруулалтын зардалд 1363.7 сая төгрөг 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар орон нутгийн хөгжлийн сангийн 16 арга хэмжээний тендерийг зарласнаас 9 арга хэмжээний тендер шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 107 | тогтоомжийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.14.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.15.нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд жилийн 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох, орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны банкнаас авсан зээлийн хүүг 1 хувь хүртэл бууруулж олгох ажилд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.16.нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээг хүнд сурталгүйгээр шуурхай шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.17.гадаад зээлийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Монгол Улсын 2023 оны төсөвт тусгасан дүнгээр бүрэн төлж барагдуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | 1.14 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж байхгүй болно.<br><br>1.15 Орон нутагт шилжин ирсэн иргэдэд дэмжлэг үзүүлэх талаар “Нээлттэй Говьсүмбэр” хөтөлбөрийн үйл ажиллагаанд бүрэн тусган батлуулсан. Ипотекийн зээлтэй холбоотой батлан даалтын сангийн шинэ хөнгөлөлтийн талаар иргэдэд Орон сууцны карпорациас 40 гаруй иргэнд мэдээлэл өгсөнөөр хаан банк 1 иргэнд ипотекийн 57.4 сая төгрөгийн зээл олгосон.<br><br>1.16. Нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнес эрхлэхээр газар эзэмших хүсэлт одоогоор гаргаагүй байна.<br><br>1.17. Дамжуулан зээл болон зээлийн хүүгийн үлдэгдэл аймгийн хэмжээнд байхгүй болно.<br><br>**Үр нөлөө:** Төрийн захиргааны албан хаагчийн орон нутагт ажилласны нэмэгдлийг 100 хувь, төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 26 хувиар тус тус нэмэгдүүлэн 1319.7 сая төгрөгийг батлуулан олгож байна.<br><br>1 иргэнд ипотекийн 57.4 сая төгрөгийн зээл олгосон. | | |
| | 107 | 2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт | Сар бүрийн төсвийн хэтрэлт хэмнэлтийн мэдээллийг цахим хуудаст бүрэн, хугацаанд нь оруулсан. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах. | 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр байхгүй болно.<br><br>2.2. 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын зардалд 7 ажлын зураг төсвийг 150.0 сая төгрөгөөр хийлгэхээр батлуулж 7 ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, 54,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 28.7 сая төгрөгөөр хамгаалалтын хашаа барих ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллаж байна.<br><br>2.3. Батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлж байгаа бөгөөд 6 сарын байдлаар ОНХС-д 3 124.4 сая.төгрөг, ОНХО-д 684.5 сая.төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгоод байна. 2.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай хэрэгжиж байгаа 4 төсөл арга хэмжээнд нийт 1,361,733,112 төгрөгийн материалын үнийн зөрүүг тооцох ажлыг зохион байгуулж ажилласан. Гүйцэтгэгч байгууллагуудад ажлын гүйцэтгэлтэй уялдуулан дээрхи үнийн дүнгийн 90 хувь олгогдсон байна.<br><br>2.5. Үнийн өсөлтийг тооцсон гүйцэтгэл 4 ажил, 2023 онд санхүүжих авто замын 2 ажлын 1,852,154,796 төгрөгийн гүйцэтгэл сангийн яамны (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-д байршсан байна. | | |
| 27 | 108 | **Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай** | Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Нийслэл, дүүргийн төсвөөс санхүүждэг нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын төрийн захиргааны албан тушаалаас бусад төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ”-ын дагуу | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **2022-12-28**<br>**Дугаар 2022_488**<br><br>5. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | төрийн захиргааны албан хаагчдын цалингийн хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Б/05 дугаар тушаалаар батлан мөрдөн ажиллаж байна. | | |
| 28 | 109 | **Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай**<br>**2023-01-11**<br>**Дугаар 2023_79**<br><br>3. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан, шаардлагатай бол зохицуулалт хийн санхүүжүүлж, цаашид холбогдох эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төсөлд батлуулж байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Санхүүгийн хяналт шалгалтын 2023 оны үйл ажиллагаанд 232.5 сая.төгрөгийг орон нутгийн төсөвт тусган батлуулж Санхүүгийн хяналт, дотоод аудитын албыг санхүүжүүлж байна. | 100 | |
| 29 | 110 | **Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2023-02-08**<br>**Дугаар 2023_55**<br><br>1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн 5.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд санхүүжих 2 төсөл, арга хэмжээ болох Боржигин чуулгын барилга, аймгийн төвийн авто замын гүйцэтгэлийн явцтай уялдуулан 06 дугаар сарын байдлаар нийт 1,112 сая төгрөгийн санхүүжилтийг тухайн онд батлагдсан дүнд багтаан гүйцэтгэгчид олгоод байна. 2 төсөл, арга хэмжээний дундаж гүйцэтгэл 63.0 хувьтай хийгдэж байна. | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын тухайн онд батлагдсан дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай | | | |
| 30 | 111 | **Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2023-02-08**<br>**Дугаар 2023_63**<br><br>3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | 2023 онд Үхэр сүргийг ээмэгжүүлэх ажил Дархан-Уул, Орхон аймгуудад хэрэгжихээр шийдвэрлэгдсэн. | - | |
| 31 | 112 | **Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2023-02-08**<br>**Дугаар 2023_68**<br><br>7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим | Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас Хөдөө.мн сайтыг шинээр нээж аймгийн кодыг үүсгүүлэн авч тус сайтын 9 цэсэнд Говьсүмбэр аймгийн танилцуулга, хөдөөгийн сэргэлт, ажлын байр, мэдээ, арга хэмжээ, төрийн үйлчлигээний байгууллагын холбоо барих мэдээлэл зэрэг нийт 55 төрлийн мэдээллийг байршуулж иргэдэд түгээж байна. Мөн төрийн цахим үйлчилгээний e-mongolia системд Говьсүмбэр аймгийн 15 байгууллагын 61 нэр төрлийн үйлчилгээг цахимжуулсан. “Нээлттэй Говьсүмбэр” хөтөлбөрийг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 15 дугаар хуралдааны 2023 оны 04 дүгээр тогтоолоор батлуулан мөрдөн ажиллаж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй хөрөнгө оруулалтын уулзалтыг 04 дүгээр | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | сарын 21-нд зохион байгуулж 50 гаруй аж ахуй нэгжийг урилгаар оролцуулж 17 аж ахуйн нэгжтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан. Мөн гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор аймагт үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалтай хувь эзэмшигч компаниудтай уулзалтыг зохион байгуулсан. Мөн шилжилт хөдөлгөөний бодлого зохицуулалт, төрийн үйлчилгээ сэдвээр төрийн байгууллагын дарга, мэргэжилтнүүдийг хамруулсан сургалтыг 3 сард зохион байгуулж 97 албан тушаалтныг хамруулсан.<br><br>**Үр нөлөө:** Хөдөө.мн сайтыг ажиллуулж манай орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад мэдээллийг хүргэж байна. Говьсүмбэр аймгийн 15 байгууллагын 61 нэр төрлийн үйлчилгээг цахимжуулсан. | | |
| 32 | 113 | **Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай**<br>**2023-04-05**<br>**Дугаар 2023_119**<br><br>2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/151 дугаар захирамжийн дагуу Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр хаах болзол хангасан 28 иргэн 10.1 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна. | 30 | |
| 33 | 114 | **Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>**2023-04-05**<br>**Дугаар 2023_120**<br><br>2.3. “Хот хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд нийгэм, эдийн засгийн бүсчлэл тогтоох схем, арга зүй, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийн төв | Говьсүмбэр аймаг нь Сүмбэр сумыг тээвэр логистикийн төв, аж үйлдвэрийн төв, Шивээговь сумыг уул уурхай, эрчим хүчний төв, Баянтал сумыг тээвэр логистикийн төв, хөнгөн үйлдвэр, боловсруулах үйлдвэрийн төв болгон хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Тус ажлын хүрээнд чойр хотын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийлгэж байна. | ҮБ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | боомтуудын тусгайлсан орон зайн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн дарга нарт; | | | |
| | 115 | 3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасугай. | чойр хотын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийлгэх ажлыг гүйцэтгүүлэхээр орон нутгийн төсвөөс 200.0 сая төгрөгийг батлуулсан. | ҮБ | |
| **Хэсгийн дундаж: 88.13 хувь** | | | | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | |
| 34 | 116 | **2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 63 дугаар тэмдэглэл**<br>**2021-12-08**<br>**Дугаар 2021_63**<br><br>ХҮ.3.1.3. Орон нутгийн түвшинд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн шалтгааныг судалж, холбогдох зохицуулалт, арга хэмжээ авахад санаачилга гарган ажиллахыг бүх аймгийн засаг дарга нарт; | Орон нутгийн түвшинд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ “Сар шинийн баяр”-ын үед 3.8-16.7 хувийн өсөлттэй байв. Үнийн өсөлтийг хэт хөөрөгдүүлэхгүйн тулд Дотооддоо үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнээр “Элбэг дэлбэг Цагаан сар-2023” үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Мөн Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яамны хамтарсан удирдамж, чиглэл, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын даргын 2023 оны “Хяналт шалгалт хийх тухай” 06 дугаар удирдамжийн дагуу 2023 оны 2 дугаар сард аймгийн төвийн худалдаа үйлчилгээний томоохон 10 газрыг хамруулан хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, хадгалалт, бүтээгдэхүүний баталгаат болон эдэлгээний хугацаа, хүнсний бүтээгдэхүүний хаяг, шошгын бүрэн бүтэн байдал, кассын үнэ, лангууны үнийн зөрүүтэй эсэхэд урьдчилсан хяналт, шалгалтыг зохион байгуулж хадгалах, хэрэглэх хугацаа хэтэрсэн, хадгалалтын горим баримтлаагүйгээс чанар, аюулгүй байдал | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | нь алдагдсан 8 нэр төрлийн 357 ш 2386751 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг ААНБ-ын дотоод хяналтаар устгуулж, хүнсний хэрэгцээнээс хасаж, хаяг шошгын зөрчилтэй 2 нэр төрлийн 19ш, 40.73 кг 653540 төгрөгийн бүтээгдэхүүнийг буцаан татан авалт хийлгэв. Шалгалтад хамрагдсан аж, ахуй нэгжүүдэд зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг чиглэл өгч арилгуулсан.<br><br>Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг сар бүр судалгаа явуулж байна. 4 дүгээр сараас өргөн хэрэглээний барааны үнэ 1000-2000 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Үүнд: үхрийн мах 1500-2000 төгрөгөөр, хонины мах 1000 төгрөгөөр, адууны мах 250 төгрөгөөр, лууван 150 төгрөгөөр, төмс 250 төгрөгөөр, гурил /алтан тариа 1кг/ 100 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна. Махны үнийн өсөлтийг бууруулахаар аймгийн Засаг даргын 2023 оны А/121 тоот захирамжаар нөөцийн махыг зах зээлийн ханшаас 2000 төгрөгөөр хямд худалдан борлуулах арга хэмжээг авч 04, 05 дугаар сард 20.0 тн махыг иргэдэд худалдан борлуулсан.<br><br>**Үр нөлөө:** үнийн өсөлтийн талаар авсан арга хэмжээний тоо-2 | | |
| 35 | 117 | **2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл<br>2022-04-20<br>Дугаар 2022_24**<br><br>XIY.8.3. Хот, суурин газруудын хөгжлийн чиг хандлагыг харгалзан газрын тухай хууль тогтоомжид заасан хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газрын тэг гортигийг шинэчлэх асуудлыг судлан зохих арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол шинэчлэл хийх зорилгоор ажлын хэсэг байгуулагдан судалгаа, шинжилгээг хийж Орон нутгийн 200 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Чойр хотын одоогийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол, шинэчлэл хийх” ажлын даалгаврыг боловсруулан, тендер зарлагдаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах шалгаруулалт хийгдэж байна. Уг ажлын хүрээнд хотын тэг гортигийг тэлэх (одоогийн төлөвлөлт 83 хувийн биелэлттэй), зөрчигдөж олгогдсон газрыг шинэчлэх, дахин төлөвлөлт хийх шаардлагатай бүсийг тодорхойлохоор тусган ажиллаж байна. | 70 | |
| 36 | 118 | **2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл** | Монгол улсад 2022 оны 05 сарын 01-ний өдрөөс эхлэн 16 насанд хүрсэн иргэн бүрт тоон гарын үсгийг олгож эхэлсэн. | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **2022-05-11**<br>**Дугаар 2022_28**<br><br>XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | Орон нутгийн иргэд, хуулийн этгээдэд тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүсэлт гаргаж 30.0 сая төгрөгийн үнэ бүхий киоск машиныг хүлээн авч иргэдэд тоон гарын үсгийг киоск машинаар олгох боломжтой болсон. Орон нутгийн зүгээс Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний улсын бүртгэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж 3.5 сая төгрөгийн өртөг бүхий иж бүрэн компьютерээр хангасан. “Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх аян”-ыг зохион байгуулж, аяны хүрээнд 11 байгууллагад сургалт, сурталчилгаа хийн, ажилтан албан хаагчдад газар дээр нь тоон гарын үсэг олгож ажилласан. Мөн тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр Хаан банктай хамтран ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 16-аас дээш насны 11562 иргэнд тоон гарын үсэг олгохоос 2023 оны эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр 5093 иргэнд тоон гарын үсгийг зохих журмын дагуу олгож, хамрагдалт 44.0 хувьтай байна. Мөн төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх ажлын хүрээнд 39 байгууллагын 100 албан хаагч албаны тоон гарын үсэг эзэмшиж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>**Хүрсэн үр дүн:**<br>Тоон гарын үсэг олголтын хувь-44.0 хувь /2023 оны хагас жилд 50 хувьд хүргэхээр төлөвлөснөөс 88 хувьд хүрсэн байна./ | | |
| 37 | 119 | **2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл**<br>**2022-08-17**<br>**Дугаар 2022_41**<br><br>YIII.6. . “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцыг 2022 оны хагас жилийн байдлаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн | 2023 онд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс аймагтай хамааралтай 4 зорилтын 17 арга хэмжээг хяналтад авч 2023 оны эхний хагас жилийн байдлаар 75.29 хувийн гүйцэтгэлтэй байна. Эрчимжүүлэх шаардлагатай 3 арга хэмжээг /Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ, Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулна, Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ/ Говьсүмбэр аймгийг 2023 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох агентлагийн дарга нарт тус тус даалгав: 1.1. Удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байгаа зорилт, арга хэмжээг жилийн эцсийн зорилтот түвшинд хүргэх; 1.2. Санхүү, хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан эхлээгүй байгаа төсөл, арга хэмжээг улсын төсвөөс гадна гадаадын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар хэрэгжүүлэх боломжийг судлан, шийдвэрлэх; 1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэх; 1.4. Улсын Их Хуралд энэ онд өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар нэн даруй хэлэлцүүлж, өргөн мэдүүлэх. | | | |
| 38 | 120 | **2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл**<br>**2022-08-24**<br>**Дугаар 2022_42**<br><br>XY.3. Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс | Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, оношилгоог 6 насны багцаар зохион байгуулж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар анхан шатлалд 0-17 насны нийт 7196 хүүхдийг үзлэгт хамруулахаас 5718 хүүхэд хамрагдаж 79.8 хувьтай, Лавлагаа шатлалын эмнэлэгт 18-с дээш насны нийт 10991 иргэн хамруулахаас 3151 иргэнийг хамруулж | 30 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | 29.1 хувьтай нийт эрт илрүүлэг үзлэг шинжилгээний дундаж 49.2 хувьтай байна. | | |
| 39 | 121 | **2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл<br>2022-10-10<br>Дугаар 2022_49**<br><br>XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав. | “Үндэсний дата төв”-д мэйл илгээж Нутгийн захиргааны 37 байгууллагын цахим хуудсыг үүлэн системд байршуулахаас 6-р сарын 30-ны өдрийн байдлаар 30 байгууллагын цахим хуудсыг байршуулаад байна. | 70 | |
| 40 | 122 | **2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл<br>2022-11-09<br>Дугаар 2022_54** | Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 5 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 6 байгууллага, Уул уурхайн жишиг Политехникийн коллежийн газар эзэмших эрх баталгаажсан. Тус газруудыг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлж, хөрөнгөнд бүртгэсэн. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | X.12.2. “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн өмчийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч, дүнг танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | | | |
| 41 | 123 | **2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл**<br>**2022-12-07**<br>**Дугаар 2022_58**<br><br>XXI.5. Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан дүнгийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Отор нүүдлийн шилжилт, хөдөлгөөнийг мал эмнэлгийн үзлэгт хамрагдсан гарал үүслийн гэрчилгээг үндэслэх, тархвар зүйн асуумжийн дагуу зохион байгуулан ажиллах талаар аймаг, сумд хооронд гэрээ байгуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг бүх шатны Засаг дарга нарт; | Аймаг дундын Малах отрын бүсэд Сүмбэр сумын 77 өрхийн 45.1 мян.тол, Төв аймгийн 5 өрхийн 5021 мал, Өвөрхангай аймгийн 2 сумын 3 өрхийн 4.5 мян.мал мал эмнэлгийн гарал, үүслийн гэрчилгээ, аймаг, сум, АДОБАЗ -тай байгуулсан гэрээний дагуу отроор өвөлжсөн. 2023 оны эхний хагас жилийн байдлаар отрын бүсэд гадны аймаг, сумдын мал байхгүй болно.<br><br>**Үр нөлөө:** Мал эмнэлгийн гарал, үүслийн гэрчилгээтэй 4.5 мян.мал отроор өвөлжүүлсэн. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 124 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | Аймгийн Засаг даргын харьяа агентлаг, сумдад төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн e-mongolia.erp системд 50 байгууллагын 412 төрийн албан хаагчийг холбож, төрийн байгууллагын мэдээллийг дотоод удирдлагын системээр солилцох албан бичиг солилцооны дундын систем(docx.gov.mn) мөн нэвтрүүлэн албан бичиг солилцох үйл ажиллагааг явуулж байна. Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ситемийн хэрэглээг сайжруулах чиглэлээр ИМонголи академийн Салбар хоорондын зохицуулалтын газартай хамтран ERP-ийн системийн ашиглалтын талаарх сургалтыг 2 удаа зохион байгуулж 59 байгууллагын 248 албан хаагчдад заавар зөвлөмж өгч ажилласан.<br>Албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагаанд төрийн байгууллагын цахим удирдлагын ERP системийг бүрэн ашиглаж байгаа бөгөөд хагас жилийн байдлаар аймгийн ЗДТГ нийт 541 албан бичиг хүлээн авч, 62 бичиг явуулсан байна.<br>Албаны цахим хаягийг албан хэрэгт тогтмол ашиглаж 32 албан бичиг хүлээн авч, 12 албан бичиг илгээсэн байна.<br>**Хүрсэн үр дүн:**<br>Ирсэн бичгийн тоо-573<br>Явсан бичгийн тоо -94 | 100 | |
| 42 | 125 | **2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр 2 дугаар тэмдэглэл**<br>**2023-01-05**<br>**Дугаар 2023_2**<br><br>IV.2.3. хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан олгох болсонтой холбогдуулан иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх чиг үүрэг бүхий хамтарсан багийг 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд аймаг, дүүрэг, сум, хороонд байгуулан ажиллуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | 2023 онд төрийн 5 байгууллагын мэдээллийн сантай тулгалт хийж өрхийн амьжиргааны түвшинг харгалзан нийт хүүхдийн 91 хувьд нь хүүхдийн мөнгөн тэтгэмж олгохоор шийдвэрлэсэн.<br><br>Үүнтэй холбогдуулан төрийн байгууллага хоорондын мэдээллийн зөрүүтэй байдлын уялдаа, холбоог зохицуулах, иргэдийг зөв мэдээллээр хангах, гомдол саналыг шуурхай шийдвэрлэх ажлын хүрээнд төрийн байгууллагын хамтарсан баг 2023 оны 01-р сард нийт 1600 иргэнд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар зөвлөгөө өгч, мэдээллийг шалгаж ажилласан. Аймгийн хэмжээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар 6581 хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгоод байна. Үүнээс 91 хүүхдэд нөхөн олголт хийсэн.<br><br>**Үр нөлөө:** хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 6581 хүүхдэд буюу нийт хүүхдийн 91 хувьд олгоод байна. | 100 | |
| 43 | 126 | **2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл** | Засгийн газрын 204 дүгээр тогтоол болон төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу орон нутгийн болон төрийн өмчит 9 байгууллагын 17 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **2023-01-18**<br>**Дугаар 2023_4**<br><br>VIII.2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, актлах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | автомашинаас үлдэх 7 автомашин, цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх 1 автомашин, дуудлага худалдаагаар оруулах 8 автомашины судалгааг гаргаж, орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх 1 автомашиныг шилжүүлж, дуудлага худалдаагаар орох машинаас 3 машиныг төвлөрүүлээд байна.<br><br>**Үр нөлөө:** 1 авто машиныг шилжүүлж, дуудлага худалдаагаар орох 3 авто машиныг орон нутгийн өмчийн газарт төвлөрүүлээд байна. | | |
| 44 | 127 | **2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл**<br>**2023-02-01**<br>**Дугаар 2023_6**<br><br>XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад; | Төрийн 3 байгууллагын 2018-2022 онуудад хийгдсэн 20 судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд бүрэн байршуулсан. Аймгийн хэмжээнд 2023 онд судалгааны ажил хийгдээгүй байна. | 100 | |
| 45 | 128 | **2023 оны 2 дугаар сарын 8-ны өдөр 8 дугаар тэмдэглэл**<br>**2023-02-08**<br>**Дугаар 2023_8** | 6 төсөл арга хэмжээнд Сангийн яамны программаар гүйцэтгэлийг хянуулан 3 аж ахуйн нэгж байгууллагад 4 983 210 343 төгрөгийн санхүүжилтийг өссөн дүнгээр олгоод байна. | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | IX.2. Монгол Улсын 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн батлагдсан төсвийн багцын дунд хийсэн хөрөнгийн зохицуулалтыг Монгол Улсын 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид зарцуулах зорилгоор санхүүжилтийн зохицуулалт хийх арга хэмжээ авахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | **Үр нөлөө:** 2023 оны хагас жилийн байдлаар 4 983 210 343 төгрөгийн санхүүжилтийг өссөн дүнгээр олгоод байна. | | |
| 46 | 129 | **2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл**<br>**2023-03-01**<br>**Дугаар 2023_10**<br><br>XVI.4.2. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | Мал, амьтны гоц халдварт шүлхийн эсрэг хаврын дархлаажуулалтад 10 ажлын хэсэг ажилласан ба тэдгээрийн шатахууны зардалд 1.6 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж, дэмжлэг үзүүлсэн. 400 айл өрхийн 17.9 мянган мал, амьтаныг шүлхийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан.<br><br>**Үр нөлөө:** Шатахууны зардалд 1.6 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэсэн. | 100 | |
| 47 | 130 | **2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл**<br>**2023-03-07**<br>**Дугаар 2023_11**<br><br>XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн | Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/41 дугаар захирамжийн 15 дугаар хавсралтаар батлагдсан “Жендерийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ”-г 2 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг 15.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөн төлвлөгөөний дагуу 2023 оны хагас жилийн байдлаар Сүхбаатар аймагт 2023 оны 04 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан туршлага түгээх, солилцох ажлын хүрээнд “Монгол эр хүний нэр хүнд, бахархал”, “Гэр бүлийн үнэ, цэнэ” сэдэвт цуврал яриа таниулгад аймгийн Эрэгтэйчүүдийн холбооны тэргүүн нийт 300 иргэн хамрагдсан. Говьсүмбэр аймгийн мастеруудын спортын гуравдугаар наадам” 2023 оны 06 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд 6 төрлөөр зохион байгуулж, шагналын зардалд 748.0 мянган төгрөгийг зарцуулсан. | 30 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав. | | | |
| | 131 | XII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, оношилгоог 6 насны багцаар зохион байгуулж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар анхан шатлалд 0-17 насны нийт 7196 хүүхдийг үзлэгт хамруулахаас 5718 хүүхэд хамрагдаж 79.8 хувьтай, Лавлагаа шатлалын эмнэлэгт 18-с дээш насны нийт 10991 иргэн хамруулахаас 3151 иргэнийг хамруулж 29.1 хувьтай нийт эрт илрүүлэг үзлэг шинжилгээний дундаж 49.2 хувьтай байна.<br><br>2022 онд Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр 2 дурантай ходоодны уян дурангийн аппарат олгосноор одоог хүртэл үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br><br>**Үр нөлөө:** Эрт илрүүлэг үзлэг шинжилгээний дундаж 49.2 хувьтай байна. | 30 | |
| 48 | 132 | **2023 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 3 дугаар тэмдэглэл**<br>**2023-03-22**<br>**Дугаар 2023_13**<br><br>IV.2. Нийслэл Улаанбаатар хот, аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршилд болон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газар нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт газар өмчлүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах | Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршил болон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газар нь аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргаагүй бөгөөд 2021-2024 он хүртэлх газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулан мөрдөн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар эзэмшигч нийт 355 нэг талбарыг газрын кадастрын мэдээллийн санд бүрэн оруулан ажилласан байна. тус нэгж талбарын газар эзэмших гэрээг жил бүр дүгнэн баталгаажуулж газрын ашиглалтад тавих ерөнхий шаардлагыг хангуулан ажиллаж байна. | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шийдвэр гаргахгүй байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, чөлөөт бүсийн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, хэрэгжилтэд газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан хяналт тавих, газар олголтыг нээлттэй, ил тод болгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав. | | | |
| 49 | 133 | **2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл**<br>**2023-04-19**<br>**Дугаар 2023_17**<br><br>XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов | Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмж байхгүй болно.<br><br>Монгол Улсын Засгийн газрын 57 дугаар тогтоолын дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулахыг хориглосны дагуу өвлийн улиралд хурдан морь уралдуулахгүй байх талаар постер бэлтгэж цахим орчноор олон нийтэд хүргэсэн. Мөн Цагдаагийн хэлтэс, сумдын Засаг дарга нартай хамтран хурдан морь уралдуулахгүй байх талаар хяналт тавьж ажиллахад ямар нэгэн зөрчил гараагүй болно. | 100 | |
| 50 | 134 | **2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл**<br>**2023-04-26**<br>**Дугаар 2023_18**<br><br>XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг | Аймгийн Засаг даргын 2023 оны “Нэгдсэн эргүүл шалгалт, сурталчилгааны ажил зохион байгуулах тухай” А/94 дүгээр захирамжаар 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдон Сүмбэр сумын 5, 6-р багийн нутгаар 3 нөхөрлөл, 6 өрхийн 17 малчин иргэдэд хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хаврын эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсанаар 2023 оны эхний хагас жилийн байдлаар ой хээрийн түймэр гараагүй. Мөн өнжмөл шар өвс, өвөлжөө, хаваржаа, отор нүүдэл, цагаан зээр зэрэгт тандалт хийсэн. тус үйл ажиллагаанд 1,700.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөн Байгаль хамгаалах сан дурын нөхөрлөл бүлгийн гал унтраах багаж хэрэгслийг | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | шалгаж. Тороосон шүүр гөвүүр тоог нэмэгдүүлэх талаарх зөвлөмж өгч ажилласан.<br><br>**Үр нөлөө:** 2023 оны эхний хагас жилийн байдлаар ой хээрийн түймэр гараагүй. | | |
| 51 | 135 | **2023 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 22 дугаар тэмдэглэл**<br>**2023-05-24**<br>**Дугаар 2023_22**<br><br>XXI.5.3. Гамшгийн улмаас хорогдсон малын сэг, зэм булшлах, устгах ажлыг шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгав. | Малын бэлчээрийн талбайд үүссэн мал, амьтны сэг зэмийг зайлуулах, булж устгах, орчныг халдваргүйжүүлэх ажлыг 2023 оны 4 дүгээр сараас эхлэн 2 үе шаттай зохион байгуулж 1462 ширхэг сэг зэмийг зайлуулж булж устгасан ба орчны 660 м/кв талбайг халдваргүйжүүлж, эрүүл ахуйг сайжруулсан. Хяналтаар зөрчил, дутагдал илрээгүй. Үхсэн мал, амьтны сэг зэмийн бохирдлоос шалтгаалан үүссэн халдварт өвчин бүртгэгдээгүй болно.<br><br>**Үр нөлөө:** 1462 ширхэг сэг зэмийг устгаж 660 м/кв талбайг халдваргүйжүүлсэн. | 100 | |
| **Хэсгийн дундаж: 79.0 хувь** | | | | | |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | |
| 52 | 136 | **Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай**<br>**2022-07-05**<br>**Дугаар 2022_6**<br><br>1. 1.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2.""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан 3 удаагийн сургалтад 113 албан хаагчийг танхимаар хамрагдаж, 424 албан хаагч цахимаар хамрагдаж сертификат авсан. Үүнд:<br><br>2023 оны 01-р сард Удирдлагын академиас зохион байгуулсан Орон нутаг дахь төрийн албан хаагчдад зориулсан “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, түүний эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд богино хугацааны сургалтын сургагч багш бэлтгэх сургалтад 3 албан хаагч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2023 оны 02-р сард “Шилжилт хөдөлгөөн” сургагч багш бэлтгэх сургалтад 2 албан хаагч, Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд цахим болон танхимаар зохион байгуулж 46 | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах; | байгууллагын 108 албан хаагч хамрагдаж сертификат авсан. Мөн тус цахим сургалтад 19 байгууллагын 424 албан хаагчийг хамруулсан. “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нээлттэй Говьсүмбэр хэлэлцүүлгийг 2023 оны 01 сард зохион байгуулж шилжин ирсэн иргэдийн төлөөллийг оролцуулан санал хүсэлтийг нь тусган ажилласан. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын танилцуулга шторк, постер бэлтгэн 15863 иргэнд хүргэсэн. Үүнд: Цаашид хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал, Эдийн засгийн нөөц боломж, Аж үйлдвэр, Төрийн үйлчилгээ, 2023 оны улсын төсөвт тусган хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг танилцуулсан. Мөн "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг иргэдэд сурталчилах ажлын хүрээнд “Говьсүмбэрт тавтай морил” пэйж хуудсыг шинээр нээн ажиллуулж байна.<br><br>**Үр нөлөө:** "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын талаар зохион байгуулсан сургалтын тоо-3, хамрагдсан албан хаагчдын тоо-537<br><br>“Нээлттэй Говьсүмбэр” хөтөлбөрийг боловсруулан 70 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. | | |
| 53 | 137 | **2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай**<br>**2022-08-01**<br>**Дугаар 2022_9**<br><br>3. 3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 3.1. “Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 277 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн аюулгүйн нөөц”-ийг тогтоосон | 1.Малчдын түвшинд өвөлжилтийн бэлтгэл 88.7%-тай хангагдсан. Аймгийн аюулгүйн нөөц 152 тн өвсөөс 784 өрхөд 191 тн өвсийг малчдад хөнгөлөлттэй үнээр олгосон. Сумдын нөөцийг тусламж шаардлагатай малчин өрхүүдэд хөнгөлөлттэй үнээр олгож дууссан.<br><br>2. 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг 91.85 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн.<br><br>3. 1 ААН-тэй хүнсний бүтээгдэхүүний нөөц, 1 ААН-тэй махны улирлын нөөц бүрдүүлэх гэрээ хийж, 20 тн махны нөөц, ОНТ-ийн 30 сая төгрөгөөр 100 тн мах нөөцлөн аймгийн Засаг даргын 2023 оны А/121 тоот захирамжаар нөөцийн махыг зах зээлийн ханшаас 2000 төгрөгөөр хямд худалдан борлуулах 4, 5 дугаар сард 2 цэгээс иргэдэд борлуулсан. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэмжээнд бүрдүүлж ажиллах; 3.2. Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах; 3.3. Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хүн амыг чанарын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой, хүртээмжтэй хангах, өвөл, хаврын улирлын хэрэгцээнд шаардагдах махны нөөцийг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх, нөөцийн махны чанарт онцгой анхаарч ажиллах; 3.4. Малын арьс, ширэнд анхан шатны боловсруулалт хийлгэж, Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах зохион байгуулалтын арга хэмжээ авах; 3.5. Аймаг, сумын хэмжээнд орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц газрын хил заагийг тодорхойлж, харьяалах аймаг, сумдад өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах; 3.6. Хадлангийн талбайг оновчтой хуваарилах, зохистой ашиглах асуудлын хүрээнд говийн бүсийн болон хадлангийн нөөц багатай аймгуудад хадлан, гар тэжээл бэлтгэхэд нь зохих дэмжлэг үзүүлж ажиллах; 3.7. Орон нутагт хийгдэж байгаа инженерийн хийцтэй худгийн чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах; 3.8. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, орлого бүрдүүлэлтэд тавих хяналтыг эрчимжүүлж ажиллах; 3.9. Цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хууль тогтоомж, батлагдсан төлөвлөгөөний дагуу | 4.Арьс, нэхий боловсруулах цех 2022 онд 3560 ш, 2023 оны 5-р сарын байдлаар 1500 ш нэхийг боловсруулан зах зээлд нийлүүлсэн.<br><br>5. ЗГ-ын тусгай хэрэгцээний Малах отрын бүсэд Говьсүмбэр аймгаас 67.0 мян.тол мал, Төв аймгаас 8.0 мян.тол мал, Өвөрхангай аймгаас 15.0 мян.тол мал өвөлжүүлэхээр шийдвэрлэсэн. 2023 оны эхний хагас жилийн байдлаар отрын бүсэд өөр аймгийн мал байхгүй байна.<br><br>6. Зүүн аймгаас 4 иргэн 6 хадлангийн салаа 113 тн өвс бэлтгэж, 22 тн өвсийг орон нутагт борлуулж 91 тн өвс нөөцөлсөн.<br><br>7. Шинээр инженерийн хийцтэй 24 худаг гаргасан. УТ-ийн хөрөнгө оруулалтаар 2, ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар 2, ХААГ 4, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 9, Умардговийн гүвээт халхын дундад талын сав газраас 7 худаг гаргах зөвшөөрөл олгож чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.<br><br>8. Малын тоо толгойн татварын орлогот 6-р сарын байдлаар 66.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 33.5 сая төгрөг төвлөрч 50.4 хувийн гүйцэтгэлтэй.<br><br>9. Цаг агаарын хүндрэлээс урьдчилан сэргийлж сум бүр эрсдлийн үнэлгээгээг боловсруулж, батлуулсан.<br><br>10. 21 га талбайгаас 177 тн төмс, 31.2 га талбайгаас 247.6 тн хүнсний ногоо хураан авч, ургац хураалтыг 100 хувь зохион байгуулсан. 11.Газар тариалангийн цахим системд 20 иргэн, ААН-ийг бүртгэсэн.<br><br>12. Ургацыг малаас хамгаалах чиглэлээр сумдын Засаг дарга, ЗДТГ-аас мал бүхий иргэдтэй уулзан, суурьшлын бүсэд мал, амьтан тэжээхгүй, хариулгагүй явуулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.<br><br>14. Аймгийн хэмжээнд төв замын дагуу төмс, хүнсний ногооны борлуулалтын 4 цэг ажиллуулан, бүтээгдэхүүнээ 5 сарын турш борлуулахад дэмжлэг үзүүлж ажилласан.<br><br>**Үр нөлөө:** Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хангалт 91.8 хувьтай. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шуурхай авч хэрэгжүүлэх; 3.10. Ургацын урьдчилсан балансыг таримлын төрөл бүрээр 8 дугаар сарын 18-ны дотор нарийвчлан гаргаж, таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавжаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга ажиллагаа, ургац хураалтын үед баримтлах технологийн ерөнхий зөвлөмжөөр тогтмол хангаж, ургац хураалтын мэдээ, тайланг үнэн зөв гаргах; 3.11. Газар тариалангийн мэдээллийн нэгдсэн санд тариаланчид, тариалангийн талбай, ургацыг бүртгэх цахим системийг нэвтрүүлж, гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгох ажлыг зохион байгуулах; 3.12. Ургацыг малаас хамгаалах, ургац хураалтын ажил дуусах хүртэл тариалангийн талбайн ойр орчимд малчин, мал бүхий этгээдийг суурьшуулахгүй байх, малыг байнгын хариулгатай байлгах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах; 3.13. Сортын үрийн хянан баталгааг хугацаанд нь хийх, дараа оны тариалалтад зориулан нөөцлөх үрийн цэвэрлэгээг шалгаж, стандарт шаардлагад нийцүүлэх, ногооны зоорь, агуулах, үтрэмийн цэвэрлэгээ, ариутгал, бүтээгдэхүүний хадгалалтад байнгын хяналт тавьж ажиллах; 3.14. Төвлөрсөн хот, суурин газар, төв замын дагуу төмс, хүнсний ногооны борлуулалтын цэг ажиллуулахад дэмжлэг үзүүлэх; | | | |
| 54 | 138 | **“Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>**2023-04-17**<br>**Дугаар 2023_01** | Ус-ду ОНӨААТҮГазар нь usdu.water-mongolia.com цахим хуудас, Шивээ-Овоо ХК нь shivee-ovoo.mn цахим хуудсыг ажиллуулан байгууллагынхаа хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, А, Б тушаал цахим хуудсандаа байршуулсан. | 30 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1.3. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэр, цалин хөлс, урамшууллын дүн, холбогдох цахим шуудангийн хаягийн мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, "Эрдэнэс Монгол" ХХК-ны гүйцэтгэх захирал С.Наранцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | |
| | 139 | 1.5. Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2008 оноос хойших шийдвэрийн талаарх мэдээллийг нэгтгэн хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн №01/181 тоот албан бичгээр 2008 оноос хойшхи гарсан шийдвэрийн талаархи мэдээллийг нэгтгэн хүргүүлсэн.<br>**Үр нөлөө:** албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн. | 100 | |
| 55 | 140 | **"Шил" ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>**2023-04-17**<br>**Дугаар 2023_01**<br>1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл болон Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 01 тоот албан даалгаврын 1.7-д заасны дагуу байгууллага эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийг ил тод болгож, хавсралт маягтын дагуу 24 байгууллагын мэдээг нэгтгэн хүргүүлсэн. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас гаргасан "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх" удирдамжийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 22-оос 24-ний хооронд хяналт шалгалтыг зохион байгуулхад Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ, Боржигин чуулга, Умард гувээт халхын дундад талын сав газрын харилцаа гэсэн 3 байгууллага сайтгүй байна. Тус шалгалтын дүн мэдээг ТЗУХ-ийн даргын 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 05/47 дугаарт албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны сайдад хүргүүлсэн. | 100 | |
| **Хэсгийн дундаж: 86.0 хувь** | | | | | |

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ДҮН

/2023 оны эхний хагас жилийн байдлаар/

| | | | Бүгд | Үүнээс | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Монгол Улсын хууль | УИХ-ын тогтоол | Улсын их хурлын байнгын хорооны | Ерөнхийлөгчийн зарлиг | Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны | Засгийн газрын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | Засгийн газрын албан Даалгавар | Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын тушаал |
| Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо | | | **54** | 7 | 2 | 4 | 5 | 3 | | 12 | | 18 | 3 | |
| Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо | | | **140** | 66 | 3 | 12 | 11 | 4 | | 19 | | 20 | 5 | |
| Үүнээс | Биелсэн 100% | | **89** | 52 | 2 | 4 | 3 | 4 | | 11 | | 10 | 4 | |
| | Хэрэгжих шатандаа | | | | | | | | | | | | | |
| | Үүний дотор | 70.0% | **32** | 10 | 1 | 5 | 6 | | | 4 | | 7 | | |
| | | 30.0% | **11** | 2 | | 2 | 2 | | | 1 | | 3 | 1 | |
| | Хугацаа болоогүй | | **6** | 2 | | 1 | | | | 3 | | | | |
| | Тасарсан | | **-** | | | | | | | | | | | |
| | Үүнээс | Зохион байгуулалтаас | **-** | | | | | | | | | | | |
| | | Хөрөнгө дутагдсанаас | **-** | | | | | | | | | | | |
| | Үнэлгээгүй ажил | | **-** | | | | | | | | | | | |
| **Биелэлтийн хувь** | | | **86.87** | **93.13** | **90.0** | **73.64** | **70.91** | **100** | | **88.13** | | **79.0** | **86.0** | |

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР